



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2008

**Энэхүү эмхтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.
Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг-Эрүүл Мэндийн Газар**

Шуудангийн хаяг: С.Зоригийн гудамж
Улаанбаатар -210648
Факс: 976-11-320633
Утас: 70111485, 325540
Э-шуудан: admin@doh.gov.mn
www.doh.gov.mn

Редактор: Ц.Содномпил, АУ-ны доктор (Ph.D)

Эмхтгэсэн: Д.Нямхорол, НЭМ-ийн магистр
Д.Баясгалан, АУ-ны магистр
С.Ариунтуяа
Т.Өнөрцэцэг
М.Мөнхзул

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Уранчимэг

Товчилсон нэр томъёоны тайлбар

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГА	Говь-Алтай
ГС	Говьсүмбэр
ДГ	Дорноговь
ДО	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ОР	Орхон
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
АД	Аймгийн дүн
УБ	Улаанбаатар
УД	Улсын дүн
ҮСГ	Үндэсний статистикийн хороо
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ДОХ	Дархлалын олдмол хамшинж
ДОТС	Богино хугацааны шууд хяналттай эмчилгээ
СТДХ	Сүрьеэтэй тэмцэх дэд хөтөлбөр
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ЖСА	Жирэмслэлтээс сэргийлэх арга
ХӨЦМ	Хүүхдийн өвчний цогц менежмент
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

Өмнөх үг

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын статистик мэдээллийн хэлтсээс тогтмол цуглуулдаг албан ёсны статистик мэдээ тайланд тулгуурлан бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын аргачлалын дагуу тооцож жил бүр эмхтгэл болгон хэвлүүлэн та бүхэнд хүргэдэг билээ.

Бид энэхүү эмхтгэлээ 2001 оноос эхлэн монгол, англи хэл дээр хэвлүүлэн, 2005 оноос эхлэн эрүүл мэндийн салбарын үндсэн үзүүлэлтийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалаар сүүлийн 3 жилээр тооцон гаргаж, эх хүүхдийн эндэгдэл, зарим халдварт өвчний сүүлийн 10 жилийн хандлага, хүн амын өвчлөлийн болон нас баралтын тэргүүлэх шалтгаануудыг тодорхойлон, эрүүл мэндийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд баяжилт хийн, үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн нийтийн хүртээл болгож байгаа билээ. 2008 онд эхийн эндэгдлийн түвшин 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтод хүрсэн үзүүлэлттэй байна.

Мөн энэхүү эмхтгэлд Засгийн газрын 2006 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн зорилт, хэрэгжилтийн явц, гарсан үр дүнгийн талаар товч танилцуулж байна.

Бүх түвшний эрүүл мэндийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон мэдээлэл хэрэглэгч бусад хүмүүст нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад бидний энэхүү эмхтгэл дэмжлэг үзүүлнэ гэдэгт бүрэн итгэлтэй байна.

ДАРГА

Ц. СОДНОМПИЛ

Гарчиг

Бүлэг 1. Монгол Улсын хүн ам

- 1.1 Хүн ам
- 1.2 Хүн амын нас, хүйсийн суварга
- 1.3 Монгол улсын хүн ам ба хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд

Бүлэг 2. Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтууд

Бүлэг 3. “Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2007-2008 он)

- 3.1. Хөтөлбөрийн хэрэгжилт
- 3.2. Хөтөлбөрийн үр дүн

Бүлэг 4. Эх хүүхдийн эрүүл мэнд

- 4.1 Эхийн эрүүл мэнд
 - 4.1.1 Жирэмсний үеийн болон төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ
 - 4.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ
 - 4.1.3 Төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээ
 - 4.1.4 Эхийн эндэгдэл
 - 4.1.5 Үр хөндөлт
 - 4.1.6 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглээ
- 4.2 Хүүхэд өсвөр үеийнхний эрүүл мэнд

Бүлэг 5. Эмнэлгийн тусламж үйлчилгээ

- 5.1 Эмнэлгийн анхдагч шатлалын тусламж, үйлчилгээ
 - 5.1.1 Өрхийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ
 - 5.1.2 Сумын болон сумдын эмнэлгийн тусламж, үйлчилгээ
- 5.2 Эмнэлгийн хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээ
- 5.3 Эмнэлгийн гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээ
- 5.4 Эмийн бүртгэлийн тухай

Бүлэг 6. Халдварт өвчин

- 6.1 Нийт халдварт өвчин
- 6.2 Гэдэсний халдвар
- 6.3 Амьсгалын замын халдвар
- 6.4 Бэлгийн замаар дамжих халдвар

Бүлэг 7. Халдварт бус өвчлөл

- 7.1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан
- 7.2 Стационарт бүртгэгдсэн өвчлөл

Бүлэг 8. Хүн амын нас баралт

Бүлэг 9. Эрүүл мэндийн эдийн засаг

- 9.1 Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн зарим үзүүлэлтүүд
- 9.2 Эмийн зардал, эмнэлгийн тусламж, үйлчилгээ шатлалаар
- 9.3 Хөрөнгө оруулалт
- 9.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт
Хавсралт

Бүлэг 10. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүд

Бүлэг 11. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд, 2008 он


БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

1.1 Монгол улсын хүн ам


Монгол улс нь засаг захиргааны нэгжийн хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагдана. Өнөөдрийн байдлаар Монгол улс нь 21 аймаг, 338 сум, 1682 багтай бөгөөд Улаанбаатар хот нь Монгол улсын нийслэл 9 дүүрэг, 132 хороодод хуваагддаг.

2008 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хүн ам 2 сая 683.5 мянгад хүрсэн бөгөөд 2007 онтой харьцуулахад 48.3 мянган хүн буюу 1.8 хувиар өссөн байна. Нийт хүн амын 61.4 хувь нь хот суурин газар, үлдсэн 38.6 хувь нь хөдөө амьдарч байна. Улаанбаатар хот 1 071.6 мянган хүн буюу нийт хүн амын 40 хувь нь оршин сууж байна. Нийт хүн амын 48.8 хувийг эрэгтэйчүүд, 51.2 хувийг эмэгтэйчүүд, насны бүтцээр авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 28.1 хувийг, 15- 64 насны хүн ам 67.8 хувийг, 65 дээш насны хүн ам 4.1 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 1.1. 2008 оны дундаж хүн амын тоо, аймгаар




Зураг 1.2 Хот, суурин газар амьдардаг хүн амын эзлэх хувь, аймгаар, 2008



1.2 Хүн амын нас, хүйсийн суварга

Монгол улсын хүн амын дийлэнх хувийг залуучууд эзэлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд төрөлтийн түвшин буурсантай холбоотойгоор хүн амын нас, хүйсийн бүтцэд гарсан өөрчлөлтийг 1992, 2008 оны хүн амын суваргаас харж болно.

Зураг 1.3 Хүн амын нас, хүйсийн суварга 1992, 2008 он



1.3 Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд

Монгол улс 1990 оноос хойш хүн ам зүйн шилжилтийн үед байгаа бөгөөд энэ нь төрөлт, нас баралтын түвшин огцом буурч, хүн ам хөгшрөх байдлаар тодорхойлогдож байна. Тухайлбал 1990 онд манай улсын хүн амын дундаж өсөлт 2.7 хувь байсан бол 2000 онд 1.4 хувь, 2003-2005 онд 1.17 болж буурсан. Харин 2007-2008 онд хүн амын өсөлт 1.5-1.8 болж өмнөх 3 жилтэй харьцуулахад 0.3-0.5 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн 1990 онд 1000 хүн амд ногдох төрөлт 35.3 байсан бол 2003 гэхэд 18.0 болж 2 дахин буурч, 2004 оноос тогтворжин 2007 онд 21.7, 2008 онд 23.7 болж өссөн байна. Нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн тоо 1990 онд 4.3 байсан бол 2000-2003 онд гэхэд 2 дахин буурсан үзүүлэлттэй байсан. Харин 2007, 2008 онд төрөлт нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ үзүүлэлт нь 2007 онд 2.3, 2008 онд 2.6 болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 1.1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2003	2004	2005	2008	2007	2008
Нийт хүн (мян)	2149.2	2407.5	2504.0	2533.1	2582.3	2594.8	2628.8	2683.5
Хотын хүн ам (хувиар)	54.8	57.2	58.5	59.1	60.2	60.9	61.0	61.4
Хөдөөгийн хүн ам (хувиар)	45.4	42.8	41.5	40.9	39.8	39.1	39.0	38.6
Насны бүлгээр (хувиар)								
0-15	41.5	33.7	32.8	32.8	32.6	28.8	28.9	28.1
15-64	54.4	62.8	63.9	63.9	63.9	67.3	67.0	67.8
65 аас дээш	4.1	3.5	3.5	3.5	3.5	4.1	4.1	4.1
Хүн ам зүйн коэффициентууд								
ТЕК	35.3	21.5	18.0	17.7	17.8	18.4	21.7	23.7
НЕК	7.9	5.9	6.1	6.1	6.1	6.1	6.2	5.7
Цэвэр өсөлт	2.7	1.5	1.2	1.16	1.17	1.23	1.55	1.80
ТНЖ	4.3	2.2	2.0	1.9	1.9	1.9	2.3	2.6

2000 оны хүн амын тооллогын дүнг үндэслэн тооцсон 2000-2025 оны хэтийн тооцооноос үзэхэд өндөр настны тоо 2005 онд 2000 оныхоос 16.2 хувиар буюу 20.1 мянган хүнээр, 2010 онд 2000 оныхоос 28.7 хувь буюу 35.6 мянгаар өснө гэсэн тооцоо гарсан байна. 2008 оны байдлаар нийт хүн амын 38.6 хувь нь хөдөө буюу сумын төв, багт амьдарч байна. Өөрөөр хэлбэл нийт хүн амын 39.4 хувь нь УБ хотод, 22.2 хувь нь аймгийн төвд үлдсэн 38.6 хувь нь хөдөө буюу сумын төв, багт амьдарч байна. 1990 оноос хойш хотжилт, нийгмийн эдийн засгийн хөгжлөө даган хүн ам төв суурин газар руу шилжих хөдөлгөөн буурахгүй байгаагаас 2000 онд нийт хүн амын 42.8 хувь нь хөдөөд оршин суудаг байсан бол 2008 онд 38.6 хувь болж буурсан байна.

БҮЛЭГ 2. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОРИЛТУУД

МХЗ-ыг 2000 оны 9 сард Дэлхийн Мянганы Дээд Хэмжээний Чуулга уулзалтад оролцсон дэлхийн 191 үндэстнийг төлөөлсөн 147 орны төр засгийн тэргүүнүүд баталж, тогтвортой хөгжил, ядууралтай тэмцэх асуудлыг дэлхийн хөгжлийн тэргүүлэх чиглэлээр сонгосноор мянганы хөгжлийн зорилтууд нь аль ч улс орны хөгжил дэвшлийг хэмжих хэмжүүр болж байна.

МХЗ-ын хүрээнд хүүхдийн эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийг сайжруулах, ХДХВ/ДОХ, хумхаа болон бусад өвчинтэй тэмцэх гэсэн эрүүл мэндтэй холбоотой 3 зорилго, 6 зорилт дэвшүүлсэн байдаг

Зорилт 6

1990-2015 онд нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны хоёроор бууруулах

Хүснэгт 2.1 Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2004	2005	2006	2007	2008	2015
Нялхсын эндэгдэл								
Улсын дундаж	63.4	31.2	22.8	20.8	19.8	17.8	19.6	-
УБ хот	70.3	32.8	23.7	18.1	19.0	14.7	17.5	-
Аймгийн дундаж	62.5	30.8	22.3	22.5	20.3	20.3	21.2	-
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл								
Улсын дундаж	87.5	42.4	29.1	26.1	24.0	22.1	23.4	29.2
УБ хот	99.9	42.4	28.9	21.7	21.8	18.8	20.8	-
Аймгийн дундаж	94.4	42.5	29.2	28.9	25.6	24.6	25.3	-

Сүүлийн 18 жилийн хугацаанд Монгол улсад нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин тогтвортой буурсныг дээрх статистик тоо мэдээллүүд нотлон харуулж байна. Энэ бууралт нь өргөн дархлаажуулалт, хүүхдийн өвчний цогц менежмент, хөхөөр хооллолтыг дэмжих зэрэг нийгмийн эрүүл мэндийн оновчтой арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байгаатай шууд холбоотой юм. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 1990-2000 оны хооронд 2 дахин, 2000-2007 онд 1.5 дахин буурч, 2008 онд 2007 онтой харьцуулахад бага зэрэг нэмэгдэж, 19.6 болсон байна.

Нялхсын эндэгдлийн шалтгаанд перинаталь үеийн эмгэг, амьсгалын болон хоол боловсруулах замын эрхтэн тогтолцооны өвчин, халдварт өвчин, төрөлхийн гажиг, осол гэмтлийн шалтгаант нас баралт зонхилдог бөгөөд сүүлийн 10 жилд перинатал үеийн болон төрөлхийн гаж хөгжлийн шалтгаант эндэгдэл эрс нэмэгдсэн байна. Тухайлбал 1998 онд нялхсын эндэгдлийн шалтгаант төрөлхийн гажиг 2.0 хувь, перинаталь үеийн эмгэг 25.0 хувийг эзэлж байсан бол 2008 онд төрөлхийн гажиг 14.0 хувь, перинаталь үеийн эмгэг 52.0 хувь болж тус тус нэмэгдсэн байна.

Амьсгалын болон хоол боловсруулах замын эрхтэн тогтолцооны өвчин, халдварт өвчний шалтгаант нялхсын эндэгдэл буурахын хирээр нийт эндэгдлийн дотор нярайн эндэгдлийн эзлэх хувь нэмэгддэг байна. Нярайн эндэгдэл нь жирэмсэн эхийн эрүүл мэнд, төрөх үеийн хүндрэлтэй ихээхэн холбоотой байдаг. Монгол улсад хүүхдийн эндэгдэл тогтвортой буурч байгаа боловч ураг, нярайн тусламж үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологи нэвтрүүлэх, ингэснээр эх, нярайн эрүүл мэндийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Зорилт 7

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг зохих насны хүн бүрт хүргэж, 1990-2015 онд эхийн эндэгдлийг дөрөвний гурваар бууруулах

Хүснэгт 2.2 Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2004	2005	2006	2007	2008	2015
Улсын дундаж	199.0	158.5	98.6	93.0	89.7	89.6	49.0	50.0
УБ хот	128	171.1	79.8	73.3	71.8	73.7	55.2	-
Аймгийн дундаж	230	153.4	109.6	105.7	88.2	102.0	44.3	-

Монгол улс 1990-2000 оны хооронд эхийн эндэгдлийн түвшингээр бүсийн орнууд болон хөгжилтэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр оронд тооцогддог байсан. 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 2003 онд 109.5 болж 1993 оноос хойш хамгийн бага түвшинд хүрч, 2004-2006 онд нэмэгдээгүй тогтвортой бага түвшинд хадгалагдаж чадсан байна.

Харин 2008 онд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 49.0 болж 1990 онтой харьцуулахад 4 дахин, 2000 онтой харьцуулахад 3 дахин, 2003-2007 оны түвшинтэй харьцуулахад 2 дахин буурсан байна. Энэ үзүүлэлт нь НҮБ-ын Хүн амын сан болон Монгол улсын засгийн газраас Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний 2 дахь хөтөлбөрийг 2002-2006 онд амжилттай хэрэгжүүлж дууссан, мөн 2007-2011 үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн үр дүн юм.

Зорилт 8

2015 он гэхэд ХДХВ/ДОХ өвчний тархалтыг зогсоож, БЗДХ-ыг бууруулж эхлэх

Монгол улсын нийт хүн амын дундах Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), дархлалын олдмол хомсдол (ДОХ)-ын тархалтын түвшин 1.0 хувиас бага байгаа нь зүүн Ази, Номхон далайн бусад зарим орнуудтай харьцуулбал ХДХВ, ДОХ-ын тархалт багатай 5 улс орны тоонд багтдаг хэдий ч ХДХВ-ын бүртгэгдсэн тохиолдол сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна.

ХДХВ-ын халдварын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэн бөгөөд 2008 оны байдлаар нийт халдвар авсан 49 тохиолдол бүртгэгдээд байна.

ХДХВ/ДОХ 49 тохиолдлын 11 нь 2007 онд, 13 нь 2008 онд тус тус бүртгэгдсэн байна. 2007 онд 1, 2008 онд 1 хүн ДОХ-ын улмаас нас баржээ.

Бүртгэгдсэн бүх тохиолдол бэлгийн замаар халдварлагдсан нь тогтоогдсон байна. ДОХ-ын хам шинж 8 хүнд илэрч эмчилгээнд (ретровирусын эсрэг эмчилгээнд) ороод байгаа ба 8 хүн ДОХ-ын улмаас нас барсан байна. ХДХВ/ДОХ-той хүмүүсийн 78.0 хувь нь эрэгтэйчүүд, 22.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Манай улсад бэлгийн замаар дамжих халдварын (БЗДХ) тархалт нэмэгдэж байгаа нь ХДХВ/ДОХ өвчний халдвар ихсэх нөхцлийг бүрдүүлж байна.

Зорилт 9

2015 онд гэхэд сүрьеэ өвчний тархалтыг зогсоож, бууруулж эхлэх

Монгол улсад сүрьеэ өвчний илрүүлэлт, эмчилгээний чанар сайжирч, нас баралтын түвшин буурч байгаа боловч өвчлөлийн түвшин нэмэгдэж байгаа нь тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болж байна.

Сүрьеэ өвчин нь улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын амьжиргааны түвшинтэй шууд хамааралтай байдаг. Манай орны хувьд 1990-ээд оноос эхэлсэн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үр дагаварууд болох инфляци, ажилгүйдэл, ядуурал, шилжилт хөдөлгөөн зэрэг нь уг өвчний тархалтад нөлөөлж байна. ДЭМБ-ын судалгаагаар Номхон Далайн Баруун бүсэд багтдаг сүрьеэгийн өвчлөл өндөртэй 7 орны 3 дугаарт Монгол улс орж байна.

Хүснэгт 2.3 Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын түвшин (100 000 хүн амд), сонгосон онуудаар

Он	1990	2000	2004	2005	2006	2007	2008	2015
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин								
Улсын дундаж	79	125	176	175	185	186	159	40
УБ хот	85	180	264	264	259	225	227	-
Аймгийн дундаж	63	99	129	123	132	123	115	-
Сүрьеэгийн нас баралтын түвшин								
Улсын дундаж	4.8	3.2	3.8	4.0	2.9	2.5	2.7	-
УБ хот	5.4	2.5	3.3	3.3	3.3	2.3	3.2	-
Аймгийн дундаж	3.9	2.0	4.5	4.3	2.5	2.8	2.4	-
ДОТС-ын хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь								
Улсын дундаж	-	100/80	100/83	100/79	100/82.1	100/83.8	100/85.0	-
УБ хот	-	100/84	100/84	100/74	100/78.4	100/80.6	100/83.2	-
Аймгийн дундаж	-	100/81	100/87	100/84	100/87.1	100/88.0	100/87.2	-

100.000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 1990 онд 79 байсан бол 2000 онд 1.5 дахин, 2004-2006 онд 2-2.3 дахин нэмэгдсэн байна. Харин 2007 оноос эхлэн уг өвчлөл буурч эхэлсэн ба 100.000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 2007 онд 166, 2008 онд 159 болжээ.

2008 оны байдлаар улсын хэмжээнд сүрьеэгийн нийт шинэ тохиолдол 4223, уушигны түрхэц эерэг шинэ сүрьеэ 1838 бүртгэгдсэн нь 2007 оны мөн үетэй харьцуулахад нийт сүрьеэгийн шинэ тохиолдол 138 тохиолдлоор буюу 3.2%-иар, уушигны түрхэц эерэг шинэ сүрьеэ 18 тохиолдлоор буюу 1.0%-иар тус тус буурсан байна.

Сүрьеэ өвчний улмаас нас барсан хүмүүсийн тоо харьцангуй буурч байна. Сүрьеэ өвчний улмаас 1992-1995 онуудад жилд дунджаар 121 хүн нас барж байсан бол 1996-1999 онуудад 113; 2000-2003 онуудад 75; 2004-2008 онуудад 80 тохиолдол болж буурчээ.

Сүрьеэгээр өвчлөгсдийн 71.0 хувь нь 15-49 насны хөдөлмөрийн насны хүмүүс байгаа бөгөөд хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд 53.0 хувь, эмэгтэйчүүд 47.0 хувийг эзэлж байна.

Дэлхийн бусад улс орнуудын адил манай улс 1990-ээд оны үеэс шууд хяналттай богино хугацааны эмчилгээний бодлого, стратегийг (ДОТС) өргөжүүлж нэвтрүүлсэнтэй

БҮЛЭГ 3. “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ (2007-2008 ОН)

Монгол улсын 2007 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 193/194/77 тоот хамтарсан тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2007 оны 10-р сарын 3-ны өдрийн 20 дугаар тогтоолын дагуу 2006 онд хэрэгжүүлсэн туршлага, сургамжууд дээр үндэслэн Засгийн газрын 2006 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг шинэчилсэн удирдамж, төлөвлөгөө, аргачлал, төсвийн дагуу 2007-2008 онд хэрэгжүүлж дууслаа.

Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн түвшинг тогтоож, эрт илрүүлэн эмчилснээр хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулах зорилгын дор 4 зорилт дэвшүүлсэн.

1. 15-с дээш насны хүн амын дунд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийж зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийн түвшинг тогтоох
2. Үзлэгээр илэрсэн өвчтэй хүмүүсийг эмчилж эрүүлжүүлэх
3. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн мэдээллийн цахим сан байгуулах
4. Хүн амын дунд эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах

3.1. Хөтөлбөрийн хэрэгжилт

Зорилт 1

15-с дээш насны хүн амын дунд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийж зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийн түвшинг тогтоох

Зорилт 2

Үзлэгээр илэрсэн өвчтэй хүмүүсийг эмчилж эрүүлжүүлэх

Хөтөлбөрт хамрагдагсад:


Улсын хэмжээнд үзлэгт хамрагдвал зохих зорилтот бүлгийн (15-аас дээш насны эрүүл мэндийн I, II, III бүлгийн хүн ам) 1 220 317 хүн амаас өвчнийг эрт илрүүлэх анхан шатны үзлэгт 1020705 хүн буюу 83.6% нь хамрагдсан байна. Анхан шатны үзлэгт хамрагдагсдын 56.7 хувь нь эмэгтэй, 43.3 хувь нь эрэгтэй хүмүүс байсан ба насны ангиллаар авч үзвэл, 15-19 насныхан 15.7 хувийг, 20-24 насныхан 14.9 хувийг нь, 25-29 насныхан 13.9 хувийг, 30-39 насныхан 34.2 хувийг, 40-49 насныхан 18.9 хувийг, 50-аас дээш насны хүмүүс 12.2 хувийг тус тус эзэлж байна.

Анхан шатны үзлэгт хамрагдагсдаас сонгогдсон өвчний сэжигтэй тохиолдол 811 820 илэрч, түүний 64.8 хувь нь дараагийн шатны буюу нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдсан байна.

Цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлэлт:



Чихрийн шижин өвчний эрт




- ◆ Цусны даралт ихсэх өвчнийг илрүүлэх_ анхан шатны үзлэгт хамрагдагсдаас цусны даралт ихсэх өвчний сэжигтэй байж магадгүй гэх тохиолдол 38.5 хувь /378 637/ илэрснээс 60.1 хувь нь /227 560 тохиолдол/ дараагийн шатны нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдсан ба үүнээс 12.3 хувийн /27 856 тохиолдол/ онош батлагдан 70.0 хувийг нь /19479 тохиолдол/ эмчилгээнд хамруулсан байна.
- ◆ Чихрийн шижин өвчин илрүүлэх анхан шатны үзлэгээр 27.5 хувь нь /268 738/ сэжигтэй илэрсэн ба 60.6 хувь /162 855 тохиолдол/ дараагийн шатны нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдан 2.9 хувьд /4688 тохиолдол / онош батлагдсанаас 44.0 хувь нь /2071 хүн/ идэвхтэй хяналтанд , 30.0 хувийг /1418 хүн/ эмчилгээнд хамруулсан байна.


Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэлт:

Хөхний хавдрыг эрт илрүүлэлт:

Умайн хүзүүний хавдар ба хавдарын урьдал өвчин





хөхний хавдар ба хавдрын урьдал өвчин



- ◆ Хөхний хавдрыг эрт илрүүлэх анхан шатны үзлэгт хамрагдагсдаас 4.2 хувь нь /19 407 тохиолдол/ сэжигтэй илэрч, 63.0 хувь /12 209 тохиолдол / дараагийн шатны нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдсанаас 5.1 хувь нь /618 тохиолдол/ хөхний өмөн болон өмөнгийн урьдал өвчинтэй нь тогтоогдсон байна. Үүнээс 81.0 хувийг /500 тохиолдол/ идэвхтэй хяналтанд, 22.0 хувийг /136 тохиолдол/ эмчилгээнд хамруулсан байна.
- ◆ Умайн хүзүүний хавдрыг эрт илрүүлэх анхан шатны үзлэгт хамрагдагсдаас 9.9 хувь нь /35267 тохиолдол/ сэжигтэй илэрч, 83.6 хувь нь /29470 тохиолдол/ нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдсанаас 9.9 хувь нь /2919 тохиолдол/ умайн хүзүүний өмөн болон хавдрын урьдал өвчний сэжигтэй гарсан байна. Үүнээс 80.0 хувийг идэвхтэй хяналтанд, 11.0 хувийг эмчилгээнд хамруулсан байна.

Сүрьеэ өвчний эрт илрүүлэлт:

БЗДХ/ХДХВ/ДОХ-ын эрт илрүүлэлт:



Сүрьеэ өвчний сэжигтэй 6.8 хувьд /68 428 тохиолдол/ гарснаас нарийн мэргэжлийн үзлэгт 80.8 хувь нь /55 290 тохиолдол/ хамрагдаж, 1.8 хувьд /969/ онош батлагдсанаас 68.4 хувь /663 тохиолдол/ идэвхтэй хяналтад , 77.0 хувь нь /748 тохиолдол/ эмчилгээнд хамруулсан байна.

- ◆ Улсын хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварын сэжигтэй тохиолдол 4.2 хувьд /41 343/ илэрснээс 89.4 хувь нь /36961 тохиолдол/ дараагийн шатны нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдсанаас 19.4 хувьд /7166 тохиолдол/ өвчний онош батлагдлаа. Илэрсэн өвчлөлийн 97.3 хувийг эмчилж, эрүүлжүүлсэн ба 81.0 хувийг

Зорилт 3

Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн мэдээллийн цахим сан байгуулах

Анхан шатны болон нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдагсдын мэдээллийг нэгтгэн, сонгосон өвчнүүдийн өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж гаргах зорилгоор зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн мэдээллийн "Healthy

Mongolian” цахим сан байгуулан ажилласан байна.

Цахим мэдээллийн санд анхан шатны болон нарийн мэргэжлийн 1 020 705 хүний үзлэгийн өгөгдлүүд орсон.

“Healthy Mongolian” программ хангамж нь хэрэглэгчид дотоод сүлжээний орчинд ажиллах ба хэрэглэгчийн серверийн мэдээнүүдийг интернэтээр дамжуулан export, import хийх замаар төв бааз руу /ЭМХҮТ, ЭМЯ сервер / мэдээллийг нэгтгэн үндэсний хэмжээнд нэгтгэгдэн нэгдсэн цахим мэдээний санг үүсгэхээр хийгдсэнээрээ онцлогтой юм.

Зорилт 4

Хүн амын дунд эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах

- ◆ Нийт хүн амд чиглэсэн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр 11 төрлийн зурагт хуудас, 11 төрлийн санамжийг 11 сэдвээр хэвлэмэл болон телевиз, радио сурталчилгааны материал боловсруулж түгээсэн байна.
- ◆ Хоёр дахь шатны эрүүл мэндийн үзлэгээр цусны даралт ихсэх өвчин, чихрийн шижин, хөхний хавдар, умайн хүзүүний хавдар, сүрьеэ БЗДХ/ХДХВ/ДОХ-ын эрсдэлтэй болон, шинж тэмдэг илэрсэн хүмүүст зориулсан 6 төрлийн зурагт хуудас, 6 төрлийн санамжийг боловсруулж түгээсэн байна.
- ◆ Хөтөлбөрийн үйл ажиллагааг сурталчилж танилцуулсан телевизийн 5 минутын нэвтрүүлэг, эрсдэлт зан үйлээс сэргийлэх 10 төрлийн 30 секундын телевизийн сурталчилгаа болон радиогийн 10 минутын 11 төрлийн нэвтрүүлэг, 30 секундын 11 төрлийн санамжийг бэлтгэж орон нутгийн телевиз, радиогоор иргэдэд сурталчилсан байна.

3.2. Хөтөлбөрийн үр дүн

1. 15-аас дээш насны 1-3-р бүлгийн нийт хүн амын 83.6%-ийг өвчлөлийг эрт илрүүлэх анхан шатны үзлэгт, 64.8%-ийг нарийн мэргэжлийн үзлэгт тус тус хамруулжээ.
2. Цусны даралт ихсэх өвчнөөр 27 856, чихрийн шижин өвчнөөр 4 688, умайн хүзүүний хавдар болон хавдрын урьдал өвчнөөр 2 919, хөхний хавдар болон хавдрын урьдал өвчнөөр 618, сүрьеэ өвчнөөр 969, БЗДХ/ХДХВ/ДОХ өвчнөөр 7166 тохиолдлуудыг тус тус илрүүлжээ.
3. Илэрсэн нийт өвчлөлөөс 67.2 хувийг эмчилгээнд, 55.0 хувийг хяналтанд авчээ.
4. Сонгогдсон өвчнүүдийн өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийх боломж бүхий үндэсний хэмжээний нэгдсэн цахим сан бүрдлээ.
5. Халдварт болон халдварт бус өвчний нийтлэг, эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэхэд чиглэсэн ижил загвар, ижил мессаж бүхий 11 төрлийн 57 000 ширхэг зурагт хуудас, 17 төрлийн 2 174 325 ширхэг санамж, 11 төрлийн телевизийн болон радиогийн нэвтрүүлэг, сурталчилгаа, санамжийг тус тус боловсруулан улс, орон даяар түгээн нэвтрүүллээ.

БҮЛЭГ 4. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД


4.1 Эхийн эрүүл мэнд

- ◆ Монгол улсын эрүүл мэндийн салбарыг 2005-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд эрүүл мэндийн нэн шаардлагатай багц тусламж, үйлчилгээнд эх, нярайн тусламж үйлчилгээ тэргүүн байр эзэлсээр байна.
- ◆ Эрүүл мэнийн сайдын 2005 оны “Эхийн эндэгдлийг бууруулах тухай” 190 дугаар тушаал, “Эхийн амрах байрны бүтэц үйл ажиллагаа, санхүүжилтын журам батлах тухай” 192 дугаар тушаал, “Эхэд ээлтэй эмнэлгийг шалгаруулах зарчим, үнэлэх аргачлалыг батлах тухай” 193 дугаар тушаалууд амжилттай хэрэгжсээр байна.

2008 онд;

- ◆ Баруун бүс нутгийн “Эх, нярайн эрүүл мэнд” сэдэвт бага хурал 2008 оны 4-р сарын 22-24-ны хооронд Ховд хотноо болсон. Тус хурлаар 2011 он хүртэлх бүсийн хамтын үйл ажиллагааны төлөвлөгөөг авч хэлэлцэж хамтын ажиллагааны тунхаг бичигт гарын үсэг зурсан.
- ◆ НҮЭМ, Үндэсний хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүдийн хамгийн гол шалгуур болох эхийн эндэгдлийн түвшин 100 000 амьд төрөлтөд 2008 оны байдлаар 49.0 болж сүүлийн 10 жилд хамгийн бага түвшинд хүрээд байна.

Зураг 4.1 Эхийн эндэгдэл 100.000 амьд төрөлтөд /1998-2008/



4.1.1. Жирэмсний үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шат болох сум, өрхийн эмнэлгийн үйлчилгээнд жирэмснийг эрт илрүүлж, хянах, эрсдэлтэй болон жирэмсний хүндрэлтэй эхчүүдийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх, хэвийн төрөлтийг их эмчийн хяналтан дор удирдах, төрсний дараах эх, нярайг хянах, гэр бүл төлөвлөлтийн асуудал, эхийн амрах байрны хэвийн үйл ажиллагааг хангах асуудлууд нэн тэргүүнд тавигдсаар байна. Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн хүндрэл, эх нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулахад жирэмсний үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ чухал юм.


Жирэмсэн эмэгтэйд үзүүлэх төрөхийн өмнөх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дараах үйл ажиллагаануудыг хамруулан ойлгодог. Үүнд:

- ◆ Жирэмснийг эрт илрүүлж, жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа эмчийн хяналтанд авах.
- ◆ Жирэмсэн эхчүүдийг цусны ерөнхий шинжилгээ, БЗДХалдварыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулах, эмчлэх
- ◆ Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлээс сэргийлэх, тэдгээрийг эрт илрүүлэх, цаг алдалгүй эмчлэх
- ◆ Жирэмсэн эхчүүдийг амин дэм болон бичил элементээр хангах
- ◆ Эхчүүдийн амрах байрны үйлчилгээг сайжруулах.

Жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсний эрт үеийн болон байнгын хяналтад орох нь хавсарсан өвчлөлийг оношлох, эмчлэх, улмаар жирэмсний болон төрөх үеийн хүндрэлийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.


2008 оны байдлаар нийт хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 83.7 хувь нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа хяналтад хамрагджээ, Хот, хөдөөгөөр авч үзвэл хотод 79.3 хувь нь, хөдөө орон нутагт тухайн эмэгтэйчүүдийн 87.2 хувь нь жирэмсний эрт үеийн хяналтад хамрагдсан байгаа нь хөдөө, орон нутагт жирэмсэн эхчүүд эрт хяналтад ордог болсныг харуулж байна. Шинээр хяналтад орсон нийт жирэмсэн эхчүүдийн 89.6 хувь нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдснаас 11.5 хувь нь цус багадалттай байна. Тухайн эмэгтэйчүүдийн 80.2 хувь тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээ хийлгэсний 1.8 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба энэ үзүүлэлт Орхон, Дархан-Уул, Баянхонгор, Сэлэнгэ, Хөвсгөл, Улаанбаатар хотод өндөр байна. Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 55.9 хувь нь рентген шинжилгээнд хамрагдаж идэвхтэй сүрьеэгийн 80 тохиолдол илэрсний 90.0 хувь нь Улаанбаатар хотод байна.

Зураг 4.2 Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь, 2008 он



Жирэмсэн эмэгтэйг төрөхөөс өмнө эмчийн зөвлөсөн хугацаанд, төрсөн эхийг төрсний дараа амаржих газраас гарснаас хойш 7 хүртэлх хоногоор амрах үйл ажиллагааг жигдрүүлэхэд эхийн амрах байрны гол зорилго оршино. “Эхийн амрах байрны бүтэц үйл ажиллагаа, санхүүжилтын журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2005 оны 192 дугаар тушаал гарснаар эхчүүдийн амрах байранд алслагдсан болон нүүдлийн маягаар амьдарч буй жирэмсэн эхчүүдийн амрах тоо, хувь жилээс жилд нэмэгдэж, аймгийн төвийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх амрах байрны ачаалал ихэссээр байна. 2008 онд эхчүүдийн амрах байр улсын хэмжээнд 343 ажиллаж байгаагаас 314 нь сумын төвд, 23 нь аймгийн төвд, Улаанбаатар хотын эмнэлэгт 3, бусад газар 3 ажилласан байна. Эдгээр байрны 98 нь зориулалтын байранд байгаа ба 245 нь эмнэлэг дотор байрлаж байна.

Зураг 3.3 Жирэмсэн байхдаа 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2008



Эхчүүдийн амрах байрны дундаж ор хоног 7.9 байна. 2008 оны байдлаар нийт төрсөн эхчүүдийн 86.6 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтад байсан байна. Харин хяналтад ороогүй төрсөн эмэгтэйчүүд 0.1 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна.

4.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ

2008 онд улсын хэмжээнд 63087 эх төрсөн нь 2007 онтой харьцуулахад 7453 тохиолдлоор нэмэгдсэн байна. Төрөлт улсын хэмжээнд бүх аймгуудад болон Улаанбаатар хотод нэмэгджээ. Нийт төрөлтийн 42.8 хувь нь Улаанбаатар хотод, 41.7 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 14.3 хувь нь сум болон сум дундын эмнэлэгт, 2.8 хувь нь хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт, 0.3 хувь нь гэртээ төрсөн байна. Нийт төрсөн эхчүүдийн 40.2 хувь нь анхны төрөлт байгаа ба нийт төрөлтийн 89.5 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн их эмч удирдан явуулсан байна. Өмнөх жилтэй харьцуулахад гэртээ төрсөн эхчүүдийн хувь хэмжээ 0.1 пунктээр, суманд төрсөн эхчүүдийн хэмжээ 2.9 пунктээр тус тус буурсан нь эмнэлгийн тусламж үйлчилгээ хот, хөдөө орон нутагт нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Нийт гэрийн төрөлтийн 209 тохиолдлоос 47.8 хувь нь эмнэлгийн тусламжгүй төрсөн ба тэдгээрийн 65.0 хувь нь /65 тохиолдол/ Улаанбаатар хотод төржээ. Өмнөх онуудтай харьцуулахад эмнэлгийн тусламж аваагүй төрсөн төрөлтийн хувь буурсаар байгаа билээ. Мөн гэрийн төрөлт нийслэл Улаанбаатар хотод буурч, хөдөөд нэмэгдсэн байна.

Хүснэгт 4.1 Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2008 он

	Нийт төрөлт	Үүнээс гэртээ	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Сум сум дундын эмнэлэгт	Бага эмчийн салбарт	Хувийн эмнэлэгт
Архангай	1989	1	1140	848	0	0
Баян-Өлгий	2647	0	1659	988	0	0
Баянхонгор	2048	5	1555	488	0	0
Булган	942	2	619	321	0	0
Говь-Алтай	1365	7	962	390	6	0
Говьсүмбэр	304	1	302	1	0	0
Дархан-Уул	2183	5	2083	95	0	0
Дорноговь	1239	6	998	66	0	0
Дорнод	1796	6	1691	99	0	0
Дундговь	978	0	705	273	0	0
Завхан	1811	1	832	662	0	0
Орхон	2232	8	2205	19	0	0
Өвөрхангай	2734	8	1541	872	4	54
Өмнөговь	1176	4	999	173	0	0
Сүхбаатар	1038	5	907	126	0	0
Сэлэнгэ	1713	3	836	304	0	0
Төв	911	0	455	456	0	0
Увс	2253	15	1349	889	0	0
Ховд	2240	2	1428	477	0	0
Хөвсгөл	3043	2	1797	1244	0	0
Хэнтий	1441	8	1109	206	1	0
Аймгийн дүн	36061	89	25152	8995	11	54
Улаанбаатар	27026	120	1216	1	0	140
Улсын дүн	63087	209	26368	8996	11	194

4.1.3 Төрсний дараах үеийн тусламж үйлчилгээ

Төрсний дараах анхаарал халамжийг сайжруулан идэвхитэй үзлэгийг эх нярайд чанартай бүрэн хийх, төрсний дараа 42 хоногтойдоо эмчид үзүүлсэн байдал, эх нярайн биеийн байдал, төрсөн эхчүүдэд хүүхдээ асрах, хөхөөр хооллох, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр зөвлөгөө өгөх нь тусламж үйлчилгээний нэг гол асуудал билээ. 2008 оны эрүүл мэндийн статистикийн бүртгэлээр хяналтад байж төрсөн эхчүүдээс төрсний дараа 42 хоногтойдоо эмчийн идэвхитэй хяналтад хамрагдсан хувь 78.2 байгаа нь өнгөрсөн оны байдалтай харьцуулахад 0.9 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь төрсний дараах хүндрэл болон эхийн эндэгдэл буурахад чухал ач холбогдолтой үзүүлэлт юм. Эрүүл мэндийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь тогтвортой нэмэгдэж 99.7 хувьтай байгаа нь 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтыг хангах боломжтой байна. 2008 онд 1 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 99.3, 5 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 95.2 байна.

Хүснэгт 4.2 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2008 он

Бүсээр	Төрсөн хүүхэд				Нийт төрөлтөд	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа /100-д/	2500 граммаас доош жинтэй хүүхдийн эзлэх хувь	Амьгүй төрөлтийн түвшин
Баруун бүс	10273	5311	4962	107.8	3.44	14.1
Төвийн бүс	8514	4409	4105	109.3	3.15	5.5
Хангай, говийн бүс	13010	6774	6236	109.2	3.93	7.7
Зүүн бүс	4282	2143	2139	100.3	3.55	8.1
Аймгийн дүн	38079	18837	17442	108.9	3.58	9.1
Улаанбаатар	27183	13988	13197	106.0	4.02	5.5
Улсын дүн	63262	32823	30639	106.5	3.76	7.5

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 46.0 хувь нь эрхтэн тогтолцооны эмгэгтэй, суурь өвчтэй, жирэмсэн эмэгтэйчүүдийн 47.1 хувь нь төмөр, 37.1 хувь нь “Д” амин дэмийн дутагдалтай байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 70.7 хувь нь зөвхөн жирэмсний сүүлийн сард төмрийн бэлдмэлийг хэрэглэжээ. Жирэмсэн эмэгтэйчүүд БЗДХалдвартай, төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрүүлэх тохиолдол ихэсч байгаа нь жирэмсний хяналт, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахыг анхааруулж байгаа юм. Нийт төрсөн эхчүүдийн 29.6 хувь нь жирэмсэн байх үедээ ямар нэгэн хавсарсан өвчнөөр өвдсөн байна. Үүнээс шээс бэлгэсийн тогтолцооны өвчин /37.2 хувь/, цус, цус бүтээх эрхтний өвчин /18.3 хувь/, цусны эргэлтийн тогтолцооны өвчин /12.2 хувь/ тэргүүлж байна. Эрүүл мэндийн статистик бүртгэлээр жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл өмнөх оныхоос буурсан хэдий ч 1000 амьд төрөлтөд 521.2 болсон ба нийт 33221 тохиолдол байгаагийн 35.3 хувь нь жирэмсэн үеийн хүндрэл, 48.4 хувь нь төрөх үеийн хүндрэл, 1.6 хувь нь төрсний дараах үеийн, 14.7 хувийг жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчин тус тус эзэлж байна. Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал болон манас таталт 62.5 хувь, төрөх үеийн хүндрэлээс ус эрт гарах 22.4 хувь, төрөх хүчний анхдагч сулралт 30.5 хувь, төрсний дараах үеийн хүндрэлээс хожуу үеийн цус алдалт 70.2 хувьтай тэргүүлж байна.

Улсын хэмжээнд амьд төрсөн 63262 хүүхдийн 3.76 хувь нь 2500 граммаас доош жинтэй төржээ. Амьгүй төрөлт амьд, амьгүй 1000 нийт төрөлтөд 7.53 байгаа ба нийт 480 тохиолдлоос баруун болон зүүн бүсэд бусад бүс нутгаас өндөр байна. Амьгүй төрөлтөд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь ихэнхи бүс нутгуудад өндөр байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 106.5 байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 1275 нь хоёр ихэр, 21 нь гурван ихэр байна.


4.1.4. Эхийн эндэгдэл

Нөхөн үржихүйн эрүүл мэнд (НҮЭМ)-ийн тусламжийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн эмнэл зүйн удирдамжийг боловсруулж хэрэгжүүлэх, эрсдэл өндөртэй эхчүүдийг нарийн мэргэжлийн шатлалын тусламжинд эрт илгээх, баг, сум, өрхийн эмч, эх баригч ба эмэгтэйчүүдийн эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нэн шаардлагатай эм багаж төхөөрөмжөөр хангах зэрэг олон арга хэмжээ авч байгаа нь эхийн эндэгдлийг бууруулахад таатай нөлөө үзүүлсээр байна.

“Эхийн эндэгдлийг бууруулах стратеги” (2005-2010), “Эхийн эндэгдлийг бууруулах тухай” Эрүүл мэндийн сайдын 2005 оны 190 дугаар тушаал гарч амжилттай хэрэгжсээр байна. Монгол улсад эхийн эндэгдэл сүүлийн 5 жилд тогтвортой буурч байна.

2008 онд улсын хэмжээнд нийт 31 эх эндсэн ба аймгаар авч үзвэл: Баян-Өлгий- 2, Завхан-2, Хэнтий-2, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл аймгуудад тус тус 1 эх эндэж, Улаанбаатар хотод нийт 15 тохиолдол гарсан байна. Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөд 49,0 болж өнгөрсөн оноос 40.6 пунктээр буурчээ. 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшингээр Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Хэнтий зэрэг аймгууд болон Улаанбаатар хотод улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь нийслэлд хүн амын механик өсөлт нэмэгдэж төрөлт ихэссэнтэй холбоотой байх талтай.

Зураг 4.4 Эхийн эндэгдэл, эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалаар, 2008 он



Эндсэн эхчүүдийн 29,0 хувь нь жирэмсний үеийн хүндрэл, 9,7 хувь нь төрөх үеийн хүндрэл, 29,0 хувь нь төрсний дараах хүндрэл, 32,3 хувь нь жирэмсэн болон төрөхөөс бусад өвчнөөс болж нас барсан байна. Төрөх үеийн болон төрсний дараах үеийн эхийн эндэгдлийн шалтгаанд төрсний дараах үеийн эрт болон хожуу үеийн цус алдалт илүүтэй тохиолдож байна. Ялангуяа төрсний дараах үеийн хүндрэлээс 70.2 хувийг төрсний дараах хожуу үеийн цус алдсанаас болж эндсэн байна. Эндсэн эхчүүдийн 70.9 хувийг 20-34 насны, 29.0 хувийг 35-аас дээш насны эмэгтэйчүүд эзэлж байна.

4.1.5 Үр хөндөлт

Монгол улсад хүн амын НҮЭМ-ийн нэг тулгамдсан асуудал бол үр хөндөлтийн түвшин буурахгүй байгаа, мөн үр хөндөлтийн тоо бодитойгоор мэдээлэгдэхгүй байгаа явдал юм. 2005 оноос үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээнд орчин үеийн аргуудыг нэвтрүүлж эхлээд байгаа боловч бодитой үр дүнд хүрэхгүй байна. Эрүүл мэндийн 2008 оны статистикаар 1000 амьд төрөлтөд 168.9; нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 13.2 үр хөндөлт ногдож байна. 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлтийн түвшин Хэнтий, Баянхонгор, Дорнод, Өмнөговь, Улаанбаатар хотод улсын дунджаас өндөр байна. Хожуу үеийн үр хөндөлтийн түвшин 3.6 хувь байгаа ба өнгөрсөн жилтэй харьцуулахад 0.5 пунктээр буурсан байна. Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 7.1 хувийг 20-иос доош насны, 67.3 хувийг 20-34 насны, 25.6 хувийг 35-аас дээш насны эмэгтэйчүүд тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад охидын үр хөндөлт нэмэгджээ.

Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 50.0 хувь нь анх удаа үр хөндөлт хийлгэсэн байна. Үр хөндөлтийн улмаас цус алдалт болон умайн дайврын үрэвслийн хүндрэл дийлэнх хувийг эзэлж байна.

4.1.6 Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ /ЖСА/

Монгол улсын хүн амын дунд жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн талаарх мэдлэг, хэрэглээ өсч байгаа нь эмэгтэйчүүд болон хосуудад төрүүлэх хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацааг зохицуулах боломжуудыг нэмэгдүүлж, хууль бус үр хөндөлтийг бууруулах нэг арга зам болж байна. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргуудад бэлгэвч (эрэгтэй, эмэгтэй), ерөндөг, норплант суулгац (дааврын), жирэмслэхээс сэргийлэх эм, үтрээний хаалт, умайн хүзүүний таглаа, эр бэлгийн эсийг хөнөөгч бодис, үрийн суваг боох (эр, эм) зэрэг аргууд багтаж байна.

2008 оны байдлаар эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр орчин үеийн ЖСА-ын хэрэглээний хувь 51.2 байгаа нь жилээс жилд өсөж байна. Нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйн 518.9 нь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэг арга хэрэглэдэг байна. Харин тэдний голчлон хэрэглэж байгаа арга нь бэлгэвч 30.7 хувь, ерөндөг 27.5 хувь, бэлдмэл

4.7 Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөл эндэгдэл

Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод 2015 он гэхэд нялхсын эндэгдлийг 2000 оны түвшнээс 1/3-ээр бууруулна хэмээн тодорхойлсон байдаг. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаарх хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илтгэх үзүүлэлтүүд болох нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нь сүүлийн жилүүдэд тогтвортой буурах хандлагатай байна. Нялхсын эндэгдэл буурахын хирээр нийт эндэгдлийн дотор нярайн эндэгдлийн эзлэх хувь нэмэгдсээр байна. Нярайн эндэгдэл нь жирэмсэн эхийн эрүүл мэнд, төрөх үеийн хүндрэлтэй ихээхэн холбоотой байдаг. 2008 оны байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 23.4 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 1.3 пунктээр, нялхсын эндэгдлийн түвшин 19.6 болж 1.8 пунктээр тус тус нэмэгджээ. Нийт нялхсын эндэгдлийн дотор нярайн эндэгдэл 65.0 хувийг эзэлж байна.

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд төрөх тойрны /перинаталь/ үед үүсэх оёг 51.9 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 17.3 хувь, төрөлхийн хэв гажил, өнгөт цогцын гажуудал 13.4 хувь байгаа нь эхний 3 тэргүүлэх шалтгаан болж байна.

Хүснэгт 4.3 Нялхас болон 1-4 хүртэлх насны хүүхдийн нас баралтын шалтгаан, байршлаар, 2008

	1 хүртэлх насны		1-4 хүртэлх насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	8.0	23.2	20.0	36.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	2.5	5.5	7.8	6.7
Төрөх тойрны /перинаталь/ үед үүсэх оёг	60.7	46.5	0.0	0.0
Төрөлхийн гажиг хэв гажил, өнгөт цогцын гажуудал	20.4	9.0	3.3	7.3
Бэртэл, хордлого ба бусад гадны шалтгааны үр дагавар	3.8	9.0	51.1	32.7

	Тэргүүлэх шалтгаан
	Хоёрдугаар шалтгаан
	Гуравдугаар шалтгаан

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан нь хотод болон хөдөөд төрөх тойрны /перинатал/ үед үүсэх оёгийн өвчлөлийн нас баралт болж байна. Харин 1-4 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд хотод бэртэл, хордлого ба бусад гадны шалтгааны үр дагавар, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчлөлийн нас баралт тэргүүлж байна.

Хүснэгт 4.4 Нялхас болон 1-4 хүртэлх насны хүүхдийн өвчлөл шалтгаан, байршлаар, 2008 он

	0-1 хүртэлх насны		1-4 насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	21.1	42.6	18.0	36.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	4.9	8.6	3.7	7.7
Төрөх тойрны /перинатал/ үед үүсэх оёг	3.3	0.7	0.0	0.0
Бэртэл, хордлого ба бусад гадны шалтгааны үр дагавар	1.1	0.5	3.9	1.2
Халдварт ба шимэгчт зарим өвчин	1.2	0.8	4.7	3.1
Арьс халимны өвчин	2.8	2.1	6.2	2.5
Чих ба хөхөнцөрийн өвчин	0.6	3.0	0.5	1.8

Тэргүүлэх шалтгаан
 Хоёрдугаар шалтгаан
 Гуравдугаар шалтгаан

Өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгалын болон хоол боловсруулах эрхтэн, шээс –бэлгсийн тогтолцооны эмгэгүүд, бэртэл хордлого ба гадны шалтгааны үр дагаварын өвчлөл илүүтэй тохиолдож байна. Өсвөр үеийнхний эндэгдэл дотор осол гэмтэл, гадны шалтгаант үхэл хот, хөдөөд аль алинд нь тэргүүлэх шалтгаан болж байна.

Хүснэгт 4.5 Хүүхэд өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, насны бүлгээр, /10000 хүн амд/, 2008 он

	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	3620.6	1076.3	818.4	604.5
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	759.4	577.4	581.0	597.8
Халдварт ба шимэгчт зарим өвчин	511.2	3644.3	227.3	215.9
Бэртэл, хордлого ба бусад гадны шалтгааны үр дагавар	335.5	244.4	287.6	392.7
Шээс бэлгсийн тогтолцооны өвчин	90.2	117.8	232.7	483.2
Арьс ба халимны өвчин	577.0	336.9	357.1	433.7

Тэргүүлэх шалтгаан
 Хоёр дугаар шалтгаан
 Гуравдугаар шалтгаан

БҮЛЭГ 5. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улсын эмнэлгийн тусламж үйлчилгээ 3 шатлалт тогтолцоотой бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээнд баримтлах зарчим нь үйлчилгээг хүн бүрт жигд, хүртээмжтэй чанартай үзүүлэх явдал юм.

- Анхдагч шатлалын тусламж үйлчилгээг УБ хотод өрхийн эмнэлгүүд, аймагт сумын болон сум дундын эмнэлэг
- Хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг УБ хотод дүүргийн нэгдсэн эмнэлэг, аймагт аймгийн болон хөдөөгийн нэгдсэн эмнэлэг
- Гуравдагч шатлалын тусламж үйлчилгээг УБ хотод клиникийн эмнэлгүүд болон төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүд тус тус үзүүлж байна.

2008 оны байдлаар клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг - 15, бүсийн оношилгоо эмчилгээний төв - 3, аймгийн нэгдсэн эмнэлэг -18, дүүргийн нэгдсэн эмнэлэг -9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг - 6, сум дундын эмнэлэг - 35, сумын эмнэлэг - 286, өрхийн эмнэлэг - 228, хувийн эмнэлэг- 1063 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Хүснэгт 5.1. Эмнэлгийн байгууллагууд , /тусламж үйлчилгээний шатлалаар/

Аймаг	Сум, дүүргийн тоо	Бага эмчийн ортой салбар/ Их эмчийн ортой салбар	Сумын эмнэлэг/ Сум дундын эмнэлэг	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг/ Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн ортой эмнэлэг	Хувийн үүдэн эмнэлэг
Архангай	19	0/1	16/2	1	5	6	2
Баян-Өлгий	13	0/0	10/3	1	4	2	3
Баянхонгор	20	0/0	17/3	1	6	6	9
Булган	16	5/0	14/2	1	3	4	6
Говь-Алтай	18	2/1	15/3	1	4	2	6
Говьсүмбэр	3	0/0	2/0	1	1	0	0
Дархан-Уул	4	0/0	3/0	1	5	12	26
Дорноговь	14	0/0	12/1	1/1	3	3	13
Дорнод	14	0/0	10/3	0	6	1	6
Дундговь	15	0/0	13/2	1	3	2	2
Завхан	24	0/0	19/3	1/1	7	5	3
Орхон	2	0/0	1/0	1	14	7	34
Өвөрхангай	19	0/2	16/1	1	6	4	9
Өмнөговь	15	0/0	13/1	1	3	2	2
Сүхбаатар	13	0/0	11/1	1	3	0	0
Сэлэнгэ	17	0/0	19/1	1/1	7	6	6
Төв	27	0/0	26/0	1	4	2	3
Увс	19	1/2	17/1	1	4	2	3
Ховд	17	0/0	14/1	1	6	5	10
Хөвсгөл	23	1/0	18/5	1	6	7	8
Хэнтий	17	2/2	15/2	1/1	3	3	8
Улаанбаатар	9	0/0	5/0	12	125	78	745
Улсын дундаж	338/9	11/8	286/35	30/6	228	159	904

5.1 Анхдагч шатлалын тусламж, үйлчилгээ


5.1.1 Өрхийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ

АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил” хөтөлбөрийн хүрээнд өрхийн эмнэлгүүдийг Улаанбаатар хот болон бүх аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн билээ. 2008 оны байдлаар 228 өрхийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 1 071.6 мянган хүн амд 125 өрхийн эмнэлэг, 21 аймгийн төвийн 531.9 мянган хүн амд 103 өрхийн эмнэлэг анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2008 онд 228 өрхийн эмнэлэгт их эмч - 794, сувилагч -748 болон нийт 2142 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

5.1.2 Сумын болон сум дундын эмнэлгийн тусламж, үйлчилгээ

2001 онд батлагдсан “Сумын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны улсын стандарт”-аар сумын эмнэлгүүд нь үйлчлэх хүрээний хүн амын тооноос хамааран 3 зэрэглэлд хуваагддаг. I зэрэглэлийн сумын эмнэлгийн үйлчлэх хүрээний хүн ам нь 4500 ба түүнээс дээш, ажиллах эмчийн доод хязгаарыг - 7, II зэрэглэлийн сумын эмнэлгийн хувьд 3001-4500 хүртэл хүн ам, ажиллах эмчийн доод хязгаарыг - 3, III зэрэглэлийн сумын эмнэлгийн хувьд 3000 хүртэл хүн ам, 1 их эмч байхаар стандартад заасан байдаг.

Зураг 5.1. Сумын эмнэлгийн их эмчийн хангамж, 2008 оны



2008 оны байдлаар:

- 288 сумын эмнэлгийн 45.0 хувь буюу 131 сум нэг их эмчтэй
- 34.0 хувь нь буюу 99 сум хоёр их эмчтэй,
- 13.0 хувь нь буюу 37 сум гурван их эмчтэй,
- 6.0 хувь буюу 16 сум гурваас дээш эмчтэй,
- 2.0 хувь буюу 7 сум эмчгүй байна.

2008 оны байдлаар эмнэлгийн нийт орны 21.8 хувь нь сумын болон сум дундын эмнэлэгт ногдож байгаа бөгөөд 2006 онтой харьцуулбал 317 ороор буюу 17.5 хувиар буурсан байна. Сумын болон сум дундын эмнэлэгт сүүлийн 3 жилд жилд дунджаар 144.2 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн байна.

Дундаж ор хоног 2006 онд 8.1 хоног байсан бол 2008 онд 7.7 болж буурсан байна. Харин сумын эмнэлэгт нэг иргэний дунджаар үзүүлсэн тоо нь 2.8 болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 5.2. Сум, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн, зарим үзүүлэлтүүд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	Онүүд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2006	2007	2008	
Эмнэлгийн орны тоо	4288	4104	3949	4106.3
Их эмчийн тоо	598	672	655	641.7
Сувилагчийн тоо	1606	1650	1681	1645.7
Дундаж ор хоног	8.1	7.9	7.7	7.9
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	146305	140897	145543	144248.3
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	2747427	2738903	2851708	2779348.0
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	2.7	2.8	2.8	2.8
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	85.6	87.9	88.1	87.2
Эхийн эндэгдэл	70.2	158.6	55.6	94.8
Нялхсын эндэгдэл	24.2	25.7	29.2	26.4

2006 онд сумын болон сум дундын эмнэлгийн түвшинд жирэмсний эрт үеийн хяналт 85.6 хувь байсан бол 2008 онд 88.1 болж нэмэгдсэн байна.

2008 онд нийт эндсэн эхийн 16.1 хувь (5 тохиолдол) нь сумын болон сум дундын эмнэлэгт эндсэн нь 2006 онтой харьцуулахад 2.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 55.6 болж 2007 оны түвшинтэй харьцуулахад 3 дахин буурсан байна.

1000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2006-2007 онд 24.2-25.7 байсан бол 2008 онд 29.4 болж нэмэгдсэн үзүүлэлт гарсан байна.

5.2 Хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээ

2008 оны байдлаар 18 аймгийн нэгдсэн эмнэлэгт 1017 их эмч, 1702 сувилагч, 2376 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 4914 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн орны тоог сүүлийн 3 жилээр авч үзвэл 2006 онд 3704, 2007 онд 3682, 2008 онд 3670 ор хүртэл бууруулсан бөгөөд 2006 онтой харьцуулахад 34 ор буюу 0.9 хувиар буурсан.

Нийт эмнэлгийн орны тавны нэг, нийт хөдөөгийн эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлэгчдийн 51.0 хувь буюу 2 хүний нэг нь аймгийн нэгдсэн эмнэлэгт ногдож байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн дундаж ор хоног 2006 онд 8.9 байсан бол 2008 онд 8.3 болж, эмнэлгийн хоног болоогүй нас баралтын эзлэх хувь 28.0 хувиас 31.8 болж 3.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 5.3. Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар болон хүртээмж, үзүүлэлтүүд, сонгосон онуудаар


Үзүүлэлт	Онүүд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2006	2007	2008	
Эмнэлгийн орны тоо	3704	3682	3670	3685.3
Дундаж ор хоног	8.9	8.5	8.3	8.6
Хоног болсоогүй нас баралтын хувь	28.0	30.2	31.8	30.0
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	120597	157137	137980	138571.3
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	1631722	1534932	1721881	1629511.7
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)	81.3	55.1	37.9	58.1
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	18.5	21.2	16.1	18.6
Жирэмсний эрт үеийн нялхлын хувь	83.5	84.8	86.0	84.8
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	31.2	34.8	29.5	31.8

Сүүлийн 3 жилд дунджаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 31.8 хувийг хөдөөнөөс буюу сум, сум дундын эмнэлгээс илгээсэн өвчтнүүд эзэлж байна. 2008 онд хөдөөнөөс аймгийн нэгдсэн эмнэлэгт ирж хэвтэн эмчлүүлэгчид өмнөх онтой харьцуулахад 5.1 хувиар буурсан байна.


Аймгийн нэгдсэн эмнэлгийн нялхсын эндэгдлийн түвшин сүүлийн 3 жилд тогтвортой нэг түвшинд байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж 18.6 байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин тогтвортой буурч байгаа бөгөөд 2006 онд 81.3 байсан бол 2008 онд 37.9 болж 2 дахин буурсан үзүүлэлт гарч байна. Нөгөөтэйгүүр 2007 онд улсын хэмжээнд эндсэн эхийн 31.0 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт эндэж байсан бол 2008 онд 26.0 хувь болж буурсан байна.

Зураг 5.2.1 Эхийн эндэгдэл, шатлалаар 2007 он



Зураг 5.2.2 Эхийн эндэгдэл, шатлалаар 2008 он



5.3 Гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээ

Улсын хэмжээнд гурван БОЭТ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Дорнод, Өвөрхангай, Ховд аймагт байдаг билээ.

Хүснэгт 5.4. БОЭТ-ийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	Онүүд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2006	2007	2008	
Эмнэлгийн орны тоо	778	795	789	787.3
Дундаж ор хоног	9.5	8.9	8.6	9.0
Хоног болоогүй нас баралтын хувь	30.2	20.4	28.6	26.4
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	25862	26771	27919	26850.7
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	346468	290893	293679	310346.7
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)	28.0	72.7	42.9	47.9
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	20.5	16.7	20.7	19.3
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	80.1	85.9	86.6	84.2
Доод шатлааас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн тоо	35.3	36.0	35.3	35.5

2008 оны байдлаар БОЭТ-үүдэд 207 их эмч, 367 сувилагч, 534 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 1066 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна. БОЭТ-ийн эмнэлгийн орны тоо сүүлийн 3 жилд 778-789 байна.

2006 онд БОЭТ-д 25.8 мянган хүн хэвтэн эмчлүүлж байсан бол 2008 онд 26.9 мянган хүн болж 2057 хүнээр нэмэгдсэн байна. БОЭТ-д жилд дунджаар 9659 хүн сумын болон сум дундын эмнэлэг, бүсийн аймгуудаас ирж хэвтэн эмчлүүлж байгаа нь нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 35.3 хувьтай тэнцэж байна.

Нөгөөтэйгүүр нэг аймгийн нэгдсэн эмнэлэгт жилд дунджаар доод шатлалын эмнэлгүүдээс 2259 хүн ирж хэвтэн эмчлүүлж байхад нэг БОЭТ-д дунджаар 3218 хүн буюу 959 хүнээр их байна.

БОЭТ-ийн дундаж ор хоног сүүлийн 3 жилд дунджаар 9.0 хоног байна. Түүнчлэн эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь 2006 онд 32.2 байсан бол 2008 онд 28.6 хувь болж буурсан байна.

Сүүлийн 3 жилд улсын хэмжээнд нялхсын эндэгдэл тогтвортой бага түвшинд байгаа хандлагын дагуу БОЭТ-ийн 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2006-2008 онд 1000 амьд төрөлтөд 20.7-16.7 байна. Эхийн эндэгдлийн байдлыг авч үзвэл 2006, 2007 ондуудад БОЭТ-д тус бүр 3, 2008 онд 2 эх эндсэн байна.

УБ хотод эмнэлгийн гуравдагч шатлалын буюу төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг клиникийн нэгдсэн эмнэлгүүд, төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүд үзүүлдэг.

Хүснэгт 5.5. УБ хотын гуравдагч шатлалын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	Онүүд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2006	2007	2008	
Эмнэлгийн орны тоо	3970	3970	3983	3974.3
Их эмчийн тоо	1147	1169	1232	1182.7
Сувилагчийн тоо	1673	1790	1878	1780.3
Дундаж ор хоног	10.9	10.8	10.5	10.7
Хоног болоогүй нас баралтын хувь	20.8	22.4	21.9	21.7
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	122178	125850	128873	125633.7
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	1158035	1050966	116979	774860.0
Доод шатлааас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн тоо /хөдөөнөөс/	30075	31802	34498	32125.0

2008 оны байдлаар 15 гуравдагч шатлалын клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүдэд 1232 их эмч, 1878 сувилагч, 2512 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 5758 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

Нийт эмнэлгийн орны тавны нэг, мөн хэвтэн эмчлүүлэгчдийн тавны нэг буюу 20 хувь УБ хотын гуравдагч шатлалын эмнэлэгт ногдож байна. Сүүлийн 3 жилд дунджаар 120 гаруй мянган хүн хэвтэн эмчлүүлж байгаагийн 25 хувийг хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгчид эзэлж байна. 2006 онтой харьцуулбал 2008 онд нийт хэвтэн эмчлүүлэгчид 5.4 хувиар, хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгч 14.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Дундаж ор хоног 2006 онд 10.9 байсан бол 2008 онд 10.5 болж буурсан байна. Түүнчлэн эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь 2006 онд 20.8 байсан бол 2008 онд 21.9 хувь болж нэмэгдсэн бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж 21.7 хувь байна.


Хүснэгт 5.6. Гуравдагч шатлалын эмнэлгүүдийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд, 2008 он

Эмнэлгүүдийн нэр	Амбулаторийн үзлэгийн тоо	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралт
УКТЭ	181914	20005	9.0	23.5
Клиникийн нэгдсэн II	94548	7148	9.3	20.0
Клиникийн нэгдсэн III	112355	14431	8.9	23.6
ЭНЭШТөв	150828	32485	6.7	19.4
Хавдар судлалын төв	65571	6386	10.2	9.3
ХӨСҮТ	109536	11115	15.7	16.4
ГССЗКЭмнэлэг	69649	10913	14.0	27.2
АӨСТөв	76899	5028	11.0	0.0
СЭМҮТ	45004	5883	29.3	0.0
Нялхасын клиникийн	0	276	10.1	0.0
УАШУТҮКорпораци	17963	3492	9.8	0.0
Шүүх эмнэлэг магадлах төвчөө	12735	0	0.0	0.0

5.4 Эмийн бүртгэлийн тухай

Манай улсын эмийн талаар төрөөс баримтлах бодлогод “эмийн улсын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох замаар эмийн эмчилгээний идэвхи, аюулгүй байдал, чанарын баталгаажуулалтад тавих шаардлагыг өндөржүүлнэ” гэж заасан билээ. Эмийг улсын бүртгэлд бүртгэснээр аюулгүй, чанарын баталгаатай эм хэрэглэх орчин бүрдэх, дотоодын зах зээлд хуурамч, дуураймал эм нэвтрэх үүд хаалгыг хаах, тэдгээрийг илрүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ач холбогдолтой. Эмийн бүртгэлийн үйл ажиллагааг 2007 онд батлагдсан Эрүүл мэндийн сайдын “Эмийн улсын бүртгэлийн дүрмийг шинэчлэх батлах тухай” 38 дугаар тушаалын дагуу явуулдаг бөгөөд одоогийн байдлаар улсын бүртгэлд импортын 1499, эх орны үйлдвэрийн 51 эм, мөн түүхий эд 67 бүртгэгдээд байна. Эмийн улсын бүртгэлд бүртгэсэн эмийн тоо тухайн жилд ирүүлсэн материалын тооноос хамааран жил бүр харилцан адилгүй байдаг. 2008 онд импортын эм 304, эх орны үйлдвэрийн эм 38, эмийн түүхий эд 42-ыг бүртгэж, 241 эмийн бүртгэлийн хугацааг сунгаж, 107 эмийн бүртгэлийн материалд өөрчлөлт оруулж, бүртгэлийн хугацаа дууссан 75 нэрийн эмийг улсын эмийн бүртгэлээс хассан байна.


Зураг 5.4.1. Улсын бүртгэлд шинээр бүртгэгдсэн импортын эмийн тоо (сүүлийн 10 жилээр)



5.4.1. Улсын бүртгэлд хамрагдсан эм /улс, орноор/


Эмийн улсын бүртгэлд 34 улсын 1499 эм бүртгэгдсэнээс ОХУ 418, Энэтхэг 201, Герман 163, Словени 105, Солонгос 97, Унгар 85, Франц 72, Болгар 65, Бангладеш 51, БНХАУ 42, бусад орны 200 эмийг тус тус бүртгүүлсэн байна. (Зураг 5.4.1)

Зураг 5.4.1. Улсын бүртгэлд хамрагдсан эм (улс)



Сүүлийн гурван жилд бүртгэгдсэн эмийг фармакологийн ангиллаар ангилахад антибиотик ба нянгийн эсрэг нөлөөт эм 140 /20%/, хоол боловсруулах системд нөлөөт эм 99 /14%/, зүрх судасны нөлөөт эм 68 /10%/, төв мэдрэлийн системд нөлөөт эм 59 /9%/, амьсгалын замын системд нөлөөт эм 56 /8%/, бусад эм бэлдмэл 269 (%) тус тус эзэлж байна.

Зураг 5.4.3. Улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, фармакологийн ангилалаар



БҮЛЭГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН

6.1 Нийт халдварт өвчин

2008 онд улсын хэмжээнд 33 төрлийн цочмог халдварт өвчний 43793 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 2711 тохиолдол буюу 10000 хүн ам тутамд ногдох өвчлөл 6.4-өөр нэмэгдсэн.

21 аймаг, Улаанбаатар хотод бүртгэгдсэн цочмог халдварт өвчний 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад Говь-Алтай, Завхан, Төв, Увс аймгуудад 4.4-19.3, Баян-Өлгий, Булган, Дорнод аймгуудад 66-69.4, Ховд аймагт 74, Хөвсгөл аймагт 94.4, Сүхбаатар аймагт 138.8 тохиолдлоор тус тус нэмэгдсэн.


2008 онд Ховд, Сүхбаатар аймгуудад вируст гепатит А, Сүхбаатар аймагт гар, хөл, амны өвчин дэгдэлт хэлбэрээр бүртгэгдсэн тул эдгээр аймгуудад 10000 хүн ам тутамд ногдох нийт цочмог халдварт өвчний өвчлөл нь өмнөх он болон энэ жилийн улсын дундажаас эрс нэмэгдсэн.

2008 онд бүртгэгдсэн цочмог халдварт өвчин Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий аймгууд, Улаанбаатар хотод улсын дундажаас /10000 хүн амд 164,7/ өндөр байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 53,7% нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн.

2008 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчнүүдийн 40.0 % бэлгийн замаар дамжих халдвар, 24.0% вирүст гепатит, 9.0 % сүрьеэ, 8.0 % гэдэсний халдварт өвчнүүд, 8.0 % гар, хөл, амны өвчин, 7.0 %-ийг амьсгалын замын халдварууд эзэлж байна.

(Зураг 6.1.)

Зураг 6.1. 2008 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчнүүдийн бүтэц



2008 онд цочмог халдварт өвчний шалтгаант нас баралтын 165 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 23 тохиолдлоор нэмэгдсэн. Нийт нас баралтын 64.0% сүрьеэ, 16.0% вирүст гепатит, 7.0%-ийг менингококкт халдварын шалтгаант нас баралт эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад сүрьеэ өвчний шалтгаант нас баралт 24 тохиолдлоор нэмэгдэж, вирүст гепатитын шалтгаант нас баралт 7 тохиолдлоор буурсан.

6.2. Гэдэсний халдвар

2008 онд улсын хэмжээнд вируст гепатит А, цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллын халдвар, балнад, суулгалт халдвар, гар хөл амны өвчин зэрэг 7 төрлийн гэдэсний халдварт өвчний 15945 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 36.4%-ийг эзэлж байна. Гэдэсний замын халдварт өвчний 58.3%-ийг вируст гепатит А, 20.1%-ийг гар хөл амны өвчин, 14.7%-ийг цусан суулга, 5.2%-ийг хүнсний гаралтай бактерт хордлого, 1.3%-ийг сальмонеллөз, 0.2%-ийг суулгалт халдвар, 0.03%-ийг балнад тус тус эзэлж байна.

6.2.1. Вируст гепатит


Улсын хэмжээнд вируст гепатит өвчний 10404 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 23,7%-ийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 375 тохиолдлоор нэмэгдсэн. Нийт вируст гепатитын өвчлөлийн 89.9%-ийг вируст гепатит А, 8,7% вируст гепатит В, 1,4 %-ийг вируст гепатит С тус тус эзэлж байна.

Вируст гепатитын 10000 хүн ам тутамд ногдох өвчлөл Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудад улсын дунджаас 1,9-34,3 тохиолдлоор өндөр байгаа бөгөөд Архангай аймгийн Жаргалант, Хашаат, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Сүхбаатар аймгийн Онгон, Түмэнцогт, Мөнххаан сум, Өмнөговь, аймгийн Цогтцэций, Цагаан-Овоо, Баяндалай, Говьсүмбэр аймгийн Шивээговь, Сүмбэр, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Улаанхус сумын Хөх хөтөл баг, Завхан аймгийн Тосонцэнгэл, Цагаанчулуут, Улиастай, Ургамал, Сантмаргац, Төв аймгийн Эрдэнэ, Баянхонгор аймгийн Галуут, Дорноговь аймгийн Хатанбулаг сумуудад вируст гепатитын өвчлөл дэгдэлт хэлбэрээр бүртгэгдсэн.

Вируст гепатит өвчнийг нийгмийн байдлаар авч үзвэл өвчлөгсдийн 38.0 % сурагчид, 21.9 % цэцэрлэгийн хүүхэд, 21.6 % гэрийн хүүхэд, 5.4 % ажилгүйчүүд, 4.6 %-ийг оюутнууд тус тус эзэлж байна.

Вируст гепатит А өвчнөөр 2-9 насны хүүхдүүд, вируст гепатит В өвчнөөр 15-29, вируст гепатит С 20-44 насны хүмүүс зонхилон өвчилж байна.

Зураг 6.2.1. Вируст гепатитийн өвчлөл, нас баралт, хандлага, 1998-2008



6.2.2. Цусан суулга

Бүртгэгдсэн нийт халдварт өвчний 5.3 хувь, гэдэсний халдварт өвчний 14.7 хувийг цусан суулга өвчин эзэлж, өвчлөл өнгөрсөн оноос 45 тохиолдлоор буурсан байна. Цусан суулга өвчний 77.2 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн ба 10000 хүн амд ногдох өвчлөл Хэнтий(18.0), Говьсүмбэр (18.2), Дорноговь аймаг (10.3), Улаанбаатар хотод (17.4) улсын дундаж (8.9)-аас өндөр, Баянхонгор аймагт өвчлөл бүртгэгдээгүй, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад өвчлөл өнгөрсөн оноосоо 1,8-5 тохиолдлоор нэмэгдсэн байна. 2008 онд цусан суулгын өвчлөлд 0-4 насны хүүхдүүд илүүтэй өртсөн байна.

6.2.3. Балнад

2008 онд улсын хэмжээнд балнад өвчний 5 тохиолдол (Улаанбаатар хотод 3, Дорнод, Өвөрхангай аймгуудад тус бүр 1) бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 0.02 %-ийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулбал 1 тохиолдлоор нэмэгдсэн.

6.2.4. Хүнсний гаралтай бактерт хордлого

2008 онд Улаанбаатар хотод хүнсний гаралтай бактерт хордлогын 612 тохиолдол, Архангай 14, Баян-Өлгий 186, Өвөрхангай 16, Өмнөговь 2, Хөвсгөл 5, Дорноговь аймагт 3 тохиолдол нийт 838 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн онтой харьцуулахад 459 тохиолдлоор нэмэгдсэн.

6.2.5. Халдварын гаралтай суулгалт халдвар

Баянхонгор (14), Орхон (19), Увс (3) аймгуудад нийт 36 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн онтой харьцуулахад 8 тохиолдлоор нэмэгдсэн (10000 хүн амд 0.1) байна.

6.2.6. Гар, хөл, амны өвчин

2008 оны 5 дугаар сард Монгол улсад гар, хөл, амны өвчний анхны тохиолдол илэрч, улмаар, улсын хэмжээнд нийт гар, хөл, амны өвчний 3210 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд ногдох өвчлөл 12.1 байв. Гар, хөл, амны өвчин нь нийт халдварт өвчний дотор 7.3%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гар, хөл, амны өвчний өвчлөл 10000 хүн амд Улаанбаатар хотод 46.3%, Дорнодод 13.0%, Сүхбаатарт 11.2%, Төв аймагт 6.0% нь бүртгэгджээ. Тус өвчний тохиолдол Баян-Өлгий, Ховд аймгуудад бүртгэгдээгүй байна.

10000 хүн амд ногдох гар, хөл, амны өвчний өвчлөл Дорнодод 56.8, Сүхбаатар аймагт 64.5 байгаа нь хамгийн өндөр байна.

Гар хөл амны өвчнөөр өвчлөгсдийн 83.5% (2680 тохиолдол)-ийг 0-9 насны хүүхдүүд эзэлж байна. Нийгмийн байдлаар авч үзвэл нийт өвчлөгсдийн 64.0%-ийг гэртээ байдаг бага насны хүүхдүүд, 15.0%-ийг цэцэрлэгийн хүүхдүүд, 16.0%-ийг сургуулийн сурагчид эзэлж байна.

6.3. Амьсгалын замын халдвар

6.3.1. Амьсгалын замын цочмог халдвар

Амьсгалын замын 9 төрлийн цочмог халдварт өвчний 7299 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 16.7%-ийг эзэлж, өвчлөлийн дотор сүрьеэ (57.8%), салхинцэцэг (28.2%), гахай хавдар (7.7%) -ын халдвар зонхилох хувийг эзэлж байна.

6.3.2. Сүрьеэ

Сүрьеэ өвчний нийт 4223 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 9.6%-ийг эзэлж байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 2362 тохиолдол байгаа нь сүрьеэгийн нийт өвчлөлийн 55.9%-ийг эзэлж байна.

Сүрьеэгийн өвчлөл өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 138 тохиолдол буюу 10000 хүн амд 0.9-өөр буурсан байна. Уушигны түрхэц эерэг шинэ сүрьеэ 1838 бүртгэгдсэн нь урьд онтой харьцуулахад 18 тохиолдлоор буурсан байна.

Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын 58.7%-ийг уушигны сүрьеэ, 41.3%-ийг бусад эрхтний сүрьеэ эзэлж, хүүхдийн сүрьеэ 426 тохиолдол илэрсэн ба энэ нь сүрьеэгийн нийт шинэ тохиолдлын дотор 10.8%-ийг эзэлж байна.


Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг насаар нь авч үзвэл :

16-44 насныхан 71.0% байгаа нь залуу хөдөлмөрийн насны хүмүүс илүүтэй өвчилж байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд 53.0% , эмэгтэйчүүд 47.0%, хүйсний харьцаа (эр: эм) = 1.1:1.0 байна.

Улаанбаатар хотод шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын 2.7%-ийг хөдөө орон нутгаас түр оршин суугч, 1.2%-ийг орон гэргүй хаяггүй хүмүүс тус тус эзэлж байна.

2008 оны байдлаар оношийн баталгаажилт 76.7%, эдгэрэлтийн түвшин 85.0%-тай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад оношийн баталгаажилт 0.5%-иар, эдгэрэлтийн түвшин 1.2%-иар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг 6.3.2.. Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын хандлага 1998-2008 он



6.3.3. Менингококкийн халдвар

2008 онд улсын хэмжээнд менингококкт халдварын 71 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн ам тутамд 0.3 тохиолдол ногдож байна. Өмнөх онтой харьцуулахад 96 тохиолдлоор буюу 10000 хүн амд 0.3 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн менингококкт халдварын өвчлөлийн 56.3% нь Нийслэл хотын хүн амын дунд бүртгэгджээ.

Менингококкт халдварт бүх насныхан өртөж байгаа боловч 0-19 насныхны дунд өвчлөл өндөр байгаа бөгөөд нийт тохиолдлын 91.5 хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд 52.1% нь эмэгтэй, 47.9 % нь эрэгтэйчүүд байна.

Менингококкт халдварын шалтгаант нас баралтын 11 тохиолдол бүртгэгдснээс Архангай, Дорнод, Увс, Сэлэнгэ, Орхон аймагт тус бүр 1, Хэнтий аймагт 2, Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй дүүрэгт тус бүр 1, Хан-Уул дүүрэгт 2 тохиолдол байна.

6.3.4. Гахай хавдар

Улсын хэмжээнд 2008 онд гахайн хавдрын өвчлөлийн нийт 560 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн ам тутамд ногдох өвчлөл 2.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 405 тохиолдол буюу 10000 хүн амд 1.6-аар буурсан байна.

2008 онд гахайн хавдрын өвчлөл Дархан-Уул аймагт 62, Сэлэнгэ аймагт 14 тохиолдлоор нэмэгдэж, Улаанбаатар хот болон бусад аймгуудад өвчлөл буурсан. Баян-Өлгий, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Ховд аймгуудад гахайн хавдрын өвчлөл бүртгэгдээгүй байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гахайн хавдарын өвчлөлд 0-19 насныхан илүүтэй өртөн, үүнээс 66.8 хувь нь сурагчдын дунд зонхилон тохиолдож байна. Гахайн хавдраар өвчлөгсдийн 55.5% эрэгтэй, 44.5%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

6.3.5. Салхин цэцэг

Улсын хэмжээнд 2008 онд салхин цэцэг өвчний өвчлөл нийт 2061 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн ам тутамд ногдох өвчлөл 7.8 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 36 тохиолдлоор нэмэгдсэн байна.

2008 онд салхин цэцэг өвчний 10000 хүн амд ногдох өвчлөл нь Дархан-Уул (29.2), Дорнод (19.2), Дорноговь (11.8), Өвөрхангай (17.0), Ховд (11) аймгуудад улсын болон сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад өндөр байна.

6.3.6. Улаан эсэргэнэ

Улсын хэмжээнд 2008 онд улаан эсэргэнэ өвчний нийт 22 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн ам тутамд ногдох өвчлөл 0.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 тохиолдлоор буурсан. 2008 онд улаан эсэргэний өвчлөл Булган аймагт 6 (10000 хүн амд 1.0), Улаанбаатар хот 16 (10000 хүн амд 0.2) бүртгэгдэж, бусад аймгуудад бүртгэгдээгүй байна.

6.3.7. Улаанууд

8 аймаг, Улаанбаатар хотод улаанууд өвчний 167 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 0.6 ногдож байгаа нь өмнөх оноос 23.9 -өөр буурсан байна. 2008 онд Булган (9), Говь-Алтай (11), Дорноговь (17), Завхан (19), Өмнөговь (2), Төв 1, Увс (9), Ховд (55), Хөвсгөл (9), Улаанбаатар (35) аймаг, хотуудад тус тус бүртгэгдэж, бусад аймгуудад өвчлөл бүртгэгдээгүй байна.

6.4 Бэлгийн замаар дамжих халдвар

БЗДХалдварт өвчний 17648 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 40.3 %-ийг эзэлж, өнгөрсөн онтой харьцуулахад 5419 тохиолдлоор ихэссэн байна. БЗДХ-ын дотор трихомониаз 36.9%, заг хүйтэн 34.8%, тэмбүү 28.2 %-ийг тус тус эзэлж байна. 10000 хүн амд ногдох өвчлөлийг авч үзвэл: тэмбүү 18.7, заг хүйтэн 23.1, трихомониаз 24.6 болж, 10000 хүн амд ногдох өвчлөл нь өнгөрсөн оны мөн үеэс 5.5-7.8 тохиолдлоор нэмэгдсэн байна.

2008 онд төрөлхийн тэмбүүгийн 17 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 10 тохиолдлоор нэмэгдсэн байна. Төрөлхийн тэмбүүгийн өвчлөл Орхон аймагт 10, Дорноговьд 2, Хэнтийд 1, Сэлэнгэд 1, Улаанбаатар хотод 3 тохиолдол тус тус бүртгэгдсэн болно.

Улаанбаатар хотод ХДХВ-ийн халдварын 13 тохиолдол бүртгэгдэж, насны бүлгээр авч үзвэл 15-44 насны хүмүүс байна.


2008 онд жирэмсэн эмэгтэйчүүдэд хийсэн 69059 үзлэгийн дүнгээс үзвэл тэмбүү 1137(1.6 %), заг хүйтэн 564(0.8%), трихомониаз 1062(1.5%) тус тус илэрсэн байна.

БҮЛЭГ 7. ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ

7.1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан

Тархвар зүйн шилжилтийн улмаас 1990 оноос эхлэн хүн амын өвчлөл, эндэгдлийн шалтгааны бүтцэд өөрчлөлт орж, “Дадал зуршил, зан үйлээс хамааралт” нэр авсан цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хорт хавдар, осол гэмтлийн шалтгаант өвчлөл давамгайлах болсон билээ.

Зураг 7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан 10000 хүн амд (2002-2008 он)



2008 онд 10000 хүн амд ногдох хоол боловсруулах тогтолцооны өвчин 839.45, шээс бэлгэсийн тогтолцооны өвчин 772.60, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 645.63, бэртэл хордлого, гадны шалтгаант өвчний үр дагавар 422.44 ногдож байгаа бөгөөд 2001 онтой харьцуулахад 25-40 хувиар нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл сүүлийн 5 жилд эдгээр өвчлөлийн түвшин буураагүй тогтвортой нэмэгдсэнийг харуулж байна.

2008 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд:

- ◆ Амьсгалын тогтолцооны өвчин /10 000 хүн амд 972.86/
- ◆ Хоол боловсруулах тогтолцооны өвчин /10 000 хүн амд 839.45/
- ◆ Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин /10 000 хүн амд 772.60/
- ◆ Цусны эргэлтийн тогтолцооны өвчин /10 000 хүн амд 645.63/
- ◆ Бэртэл хордлого, гадны шалтгаант өвчний үр дагавар /10 000 хүн амд 422.44/

2008 онд хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар авч үзвэл хотод амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин, осол гэмтлийн шалтгаант өвчин, хөдөөд амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин, шээс бэлгэсийн тогтолцооны өвчин хамгийн өндөр буюу тэргүүлэх 3 шалтгаанд орж байна. Тухайлбал 10000 хүн амд ногдох амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин хотод 878.18, хөдөөд 1034.77, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин хотод 836.66, хөдөөд 841.28, шээс бэлгэсийн тогтолцооны өвчин хотод 679.35, хөдөөд 833.57, осол гэмтлийн шалтгаант өвчлөл хотод 803.05, хөдөөд 173.56, цусны эргэлтийн тогтолцооны хотод 650.57, хөдөөд 642.41 ногдож байна.

Хүснэгт 7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2008 оны байдлаар

	Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	Бэртэл хордлого, осол гэмтлийн шалтгаант өвчин
Байршил						
Хот	6519.99	878.18	838.66	679.35	650.57	803.05
Хөдөө	5171.84	1034.77	841.28	833.57	642.41	173.58
Бүсээр						
Баруун	4424.80	892.74	702.28	804.00	538.77	104.81
Хангай говь	5409.93	968.75	871.86	895.26	782.01	181.64
Төв	5745.80	1284.48	918.17	883.63	692.69	258.99
Зүүн	5470.03	1197.27	1002.81	658.02	499.63	203.20
Улсын дүн	5704.74	972.86	839.45	772.60	645.63	422.44

Тайлбар: -СГ-ын Бүс нутгийн ангилал

Баруун бүсийн аймгууд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд

Хангай говийн бүсийн аймгууд: Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон

Төвийн бүсийн аймгууд: Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Говьсүмбэр

Зүүн бүсийн аймгууд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий

Хүн амын өвчлөлийг бүс нутгаар авч үзвэл баруун бүсэд амьсгалын тогтолцооны өвчин (892.74), шээс бэлгэсийн тогтолцооны өвчин (804.00), хоол шингээх эрхтэн тогтолцооны (702.28) өвчнүүд, хангай говийн бүсэд амьсгалын эрхтэн тогтолцоо (968.75), шээс бэлгэсийн тогтолцоо (895.26), хоол шингээх эрхтэн тогтолцооны (871.86) өвчнүүд, төвийн болон зүүн бүсэд амьсгалын эрхтэн тогтолцоо (1284.48 ба 1197.27), хоол шингээх эрхтэн тогтолцоо (918.17 ба 1002.81), шээс бэлгэсийн тогтолцооны (883.63 ба 658.02) өвчнүүд тэргүүлэх 3 шалтгаанд орж байна.

Нөгөөтэйгүүр амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин төвийн болон зүүн бүсэд, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин төвийн болон зүүн бүсэд, шээс бэлгэсийн тогтолцооны өвчин баруун, хангай говийн болон төвийн бүсэд, цусны эргэлтийн тогтолцооны өвчин төвийн болон хангайн бүсэд, осол гэмтлийн шалтгаант өвчин төвийн болон зүүн бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр байна.

7.2 Стационарт бүртгэгдсэн өвчлөл

2008 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд

- Амьсгалын тогтолцооны өвчин / 10000 хүн амд 351.55/
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин / 10000 хүн амд 337.82/
- Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин / 10000 хүн амд 322.11 /
- Цусны эргэлтийн тогтолцооны өвчин / 10000 хүн амд 312.77/

Хүснэгт 7.2. Стационарт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн түвшин 10000 хүн амд, 2008 он

Өвчний ангилал (ӨОУА-10)	Сумын хүн амын өвчлөл	Аймгийн хүн амын өвчлөл	УБ хотын хүн амын өвчлөл	Нийт хүн амын өвчлөл
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	318.02	239.14	256.71	322.11
Амьсгалын тогтолцооны өвчин	312.00	303.23	336.10	351.55
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	183.42	354.89	376.48	337.82
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	247.47	247.93	320.05	312.77
Мэдрэлийн тогтолцооны өвчин	70.07	182.93	198.76	171.85
Бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагавар	34.61	109.85	136.77	99.17
Халдварт ба шимэгч зарим өвчин	39.80	159.84	103.00	100.40
Яс булчин холбох нэхдэсийн өвчин	52.31	55.41	90.95	82.26
Арьс ба халимны өвчин	43.19	71.03	69.52	69.16
Сэтгэцийн ба аягийн эмгэг	11.09	46.92	57.58	43.50
Хавдар	11.80	26.70	85.65	48.09
Нүд ба түүний дайврын өвчнүүд	1.80	13.06	41.38	24.80
Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчинүүд	10.00	18.03	28.68	21.43
Чих ба хөхөнцрийн өвчин	9.65	16.00	19.26	17.97
Бусад	173.06	549.37	457.50	397.88
Бүгд	1518.27	2394.32	2578.39	2400.55

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтцийг байршлын хувьд авч үзэхэд ялгаатай байдал ажиглагдаж байна. Жишээ нь: Сумын болон аймгийн хүн амын эмнэлэгт хэвтэж эмчлүүлэгсдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд шээс бэлгэсийн тогтолцооны болон хоол шингээх эрхтний өвчлөл орж байхад Улаанбаатар хотын эмнэлэгүүдэд хэвтэж эмчлүүлэгчдийн тэргүүлэх шалтгаанд хоол шингээх эрхтний болон цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлүүд тэргүүлж байна.

2008 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны дотор зонхилж буй өвчнүүдийг авч үзвэл: Шээс бэлгэсийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 69.1 хувийг бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчний дотор уушигны хатгалгааны улмаас хэвтэн эмчлүүлэгчид 41.9 хувийг, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг 25.6 хувийг, цусны эргэлтийн тогтолцооны өвчний дотор даралт ихсэх өвчин 33.2 хувийг тус тус эзэлж байгаа нь эдгээр өвчнүүд хүн амын дунд зонхилон тохиолддогийг харуулж байна.

Бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин нь 2000 онд шээс бэлгэсийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 56.7 хувийг эзэлж байсан бол 2004 онд 65.4 хувь,

Хүснэгт 7.3. Зонхилон тохиолдох стационарын өвчлөлийн бүтэц, хувиар, 2008 он

Өвчний ангилал (ӨОУА-10)	Зонхилох шалтгаан	Өвчлөлийн тухайн бүлэгт эзлэх хувь								
		2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008
Шээс бэлгэсийн тогтолцоо	Бөөрний сувганцрын үрэвсэл (N10-N18)	58.70	55.76	59.03	63.14	65.41	69.06	69.7	67.8	69.1
Амьсгалын тогтолцооны эмгэг	Хатаалгаа (J12-J18)	48.75	42.89	41.01	42.87	43.24	39.83	38.6	40.5	41.9
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Элэгний эмгэг (K70.K73.K74.K71-K73.K75-K77)	18.90	19.30	21.52	21.82	23.73	25.86	24.9	25.1	25.6
	Мухар олгойн өвчин (K35-K38)	26.57	24.33	22.22	22.66	21.43	20.22	19.4	18.6	17.0
	Цөсний жүүдийн өвчнүүд (K80-K81)	14.64	14.50	14.92	16.45	15.84	15.57	15.3	13.97	13.7
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	Даралт ихсэх өвчнүүд (I10.I11-I15)	34.66	34.66	34.44	32.64	32.3	31.30	32.6	32.1	33.2
	Зүрхний ишеми өвчнүүд (I20.I23-I25)	19.19	20.29	20.91	23.46	25.73	26.28	26.3	29.3	30.1
Мэдрэлийн тогтолцооны өвчин	Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг (G50-59)	18.09	19.21	19.71	20.92	20.5	23.40	21.7	22.1	24.3
	Эпилепси (G40-G41)	11.69	10.78	11.35	12.63	12.99	12.35	12.5	11.7	11.2

Уушгины хатгаа өвчин 2000 онд амьсгалын тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 46.7 хувийг эзэлж байсан бол 2004 онд 43.2 хувь, 2008 онд 41.9 хувь болж, 2000 онтой харьцуулахад 2008 онд 4.8 хувиар буурсан байна.


2000 онд хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор 18.9 хувийг элэгний эмгэг, 14.6 хувийг цөсний өвчнүүд эзэлж байсан бол 2008 онд элэгний эмгэг нь 25.6 болон нэмэгдэж, харин цөсний өвчин 13.7 болж буурсан байна. Харин цочмог мухар олгойн үрэвсэл өвчин 2000 онд 26.6 хувийг эзэлж байсан бол 2004 онд 21.3 хувь, 2008 онд 17.0 хувь болж тус тус буурсан байна.

Зүрхний ишеми өвчин нь 2000 онд цусны эргэлтийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 19.2 хувийг эзэлж байсан бол 2004 онд 25.7 хувь, 2008 онд 30.1 хувь болж, 2000 онтой харьцуулахад 2008 онд 10.9 хувиар нэмэгдсэн байна.

БҮЛЭГ 8. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

1995 оноос хойш хүн амын нас баралтын шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, осол гэмтлийн шалтгаант нас баралт тогтмол эхний байруудыг эзэлж жил ирэх тутам эдгээр өвчний улмаас нас барсан хүний тоо нэмэгдсээр байна.

Зураг 8.1. Нас баралтын зонхилох шалтгаан хүйсээр, 2008



2008 онд хүн амын нас баралтын шалтгааны 36.1 хувийг цусны эргэлтийн тогтолцооны өвчин, 20.7 хувийг хавдар, 16.4 хувийг осол гэмтэл, хордлого ба гадны шалтгааны өвчлөл эзэлж байна. Өөрөөр хэлбэл жилд дунджаар 5500 гаруй хүн буюу нас барсан гурван хүний нэг цусны эргэлтийн тогтолцооны өвчин, 2500-3000 хүн буюу таван хүний нэг нь хавдар, осол гэмтэл, хордлого ба гадны шалтгааны улмаас тус тус нас барж байна.

2008 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд:


- Цусны эргэлтийн тогтолцооны өвчин (10000 хүн амд 20.54)
- Хавдар (10000 хүн амд 11.80)
- Бэртэл хордлого гадны шалтгаант үр дагавар (10000 хүн амд 9.33)
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин (10000 хүн амд 5.27)
- Төрөх тойрны (перинаталь) үед үүсэх оёг (10000 хүн амд 2.42) орж байна.

Хүн амын нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 68.56, 10 000 эмэгтэй хүн амд 44.64 ногдож байна.

Цусны эргэлтийн тогтолцооны өвчний улмаас жил бүр 5500-6000 хүн буюу 3 хүний нэг нас барж байгаа бөгөөд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

2008 онд цусны эргэлтийн тогтолцооны өвчний нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 22.02, 10 000 эмэгтэй хүн амд 18.76 ногдож байна.

Зураг 8.2. Цусны эргэлтийн тогтолцооны өвчний шалтгаант нас баралт (бүс нутгаар), 2008




Цусны эргэлтийн тогтолцооны өвчний улмаас нас барах явдал хангай говийн бүсэд өндөр, зүүн бүсийн аймгуудад бага байна.

Хорт хавдар өвчний улмаас нас барах нь сүүлийн 1990 оноос хойш хүн амын нас баралтын 2 дахь тэргүүлэх шалтгаан болсоор байна.


2008 оны байдлаар хорт хавдар өвчний улмаас нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 13.45, 10 000 эмэгтэй хүн амд 10.01 ногдож байна. Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушиг, улаан хоолой, түрүү булчирхайн хорт хавдар, эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, улаан хоолой, умайн хүзүү, уушигны хорт хавдар өвчний улмаас нас барах нь илүүтэй байна.

Зураг 8.3. Эрэгтэйчүүдийн хорт хавдар өвчний нас баралтын тэргүүлэх шалтгаан*, хувиар, 2008 он



* Эх сурвалж: хавдар судлалын үндэсний төв


Зураг 8.4. Эмэгтэйчүүдийн хорт хавдар өвчний нас баралтын тэргүүлэх шалтгаан, хувиар, 2008 он



2008 оны байдлаар хорт хавдартай хэмээн оношлогдсон хүн амын 73.4 хувь нь өвчнийхөө III, IV үе шатанд орсон үедээ оношлогдож, нас барсан нийт хүн амын 44.2 хувь нь анх оношлогдсоноосоо хойш 1 жил хүртлэх хугацаанд амьдарсан байна.

Осол гэмтэл хордлого, гадны шалтгаант өвчний улмаас нас барах тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж 1990 онд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааны дотор 5 дугаарт, 1994 онд 4 дүгээрт орж байсан бол 2000 оноос хойш тогтмол 3 дах шалтгаан болсоор байна. 10000 хүн амд ногдох осол гэмтлийн шалтгаант нас баралт 1995 онд 6.0, 2000 онд 7.6, 2007 онд 11.69 болж, 2007 оныг 2000 онтой харьцуулахад 1.8 дахин нэмэгдсэн байна. Харин 2008 онд сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд анх удаа осол гэмтлийн шалтгаант нас баралт буурч, 10 000 хүн амд 9.33 ногдож байна.

Зураг 8.5. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын хэлбэр, 10000 хүн амд, 2008 он



Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг хэлбэрээр авч үзвэл 19.7 хувь нь зам тээврийн осол, 16.3 хувь нь амиа хорлох, 10.4 хувь нь бусдад хорлогдсон ба 46.9 хувь нь бусад ослоор нас барсан байна. Нөгөөтэйгүүр эрэгтэйчүүдийн амиа хорлох, бусдад хорлогдож амь насаа алдах, зам тээврийн осолд өртөж амь насаа алдах явдал эмэгтэйчүүдээс их байна. Энэ үзүүлэлтийг 10000 хүн амд харьцуулан авч үзвэл: амиа хорлосон тохиолдлын тоо 4 дахин, бусдад хорлогдсон тохиолдлын тоо 7 дахин, зам тээврийн ослын тохиолдлын тоо 5 дахин их байна.


БҮЛЭГ 9. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭДИЙН ЗАСАГ

9.1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт¹

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн 2000-2007 оны үзүүлэлтийг гүйцэтгэлээр, 2008 оны үзүүлэлтийг тодотгосон төсвийн дүнгээр толилуулж байна.

Эрүүл мэндийн нийт зардал бодит тоон дүнгээрээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа боловч ДНБ-д эзлэх хувь сүүлийн жилүүдэд бага зэрэг буурах хандлагатай байна.

Зураг 9.1.1 ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардал (хувиар)



Эх сурвалж: Санхүү, хөрөнгө оруулалтын газар, ЭМЯ, 2008 он


Эрүүл мэндийн салбарын нийт зардлыг 2008 онд урьд оны гүйцэтгэлээс 37.4 хувиар нэмэгдүүлэн төсөвлөсөн ба эрүүл мэндийн зардалд тэргүүлэх байр эзэлдэг цалингийн зардлыг 49.2, эмийн зардлыг 43.1, тогтмол зардлыг 17.8, хөрөнгийн зардлыг 53.7 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.

Цалингийн зардлыг 49.2 хувиар нэмэгдүүлэн төсөвлөсөн нь нэгдүгээрт, ЗГ-ын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 351 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн доод жишгийг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон, хоёрдугаарт, “Эрүүл мэндийн тухай” хуулинд 2007 оны 11 дүгээр сард нэмэлт, өөрчлөлтөөр орсон 26¹.1.3 дахь заалт хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна.

Бусад зардлыг инфляцын түвшин, хэрэглээний үнийн өсөлт зэрэгтэй холбон нэмэгдүүлэн төсөвлөжээ.

¹Эрүүл мэндийн сайдын багцын үзүүлэлтээр тодорхойллоо.

Зураг 9.1.2 Эрүүл мэндийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр (хувиар)




Эх сурвалж: Санхүү, хөрөнгө оруулалтын газар, ЭМЯ, 2008 он

2007 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2008 онд улсын төсвийн санхүүжилтийг 42.9, ЭМД-ын сангийн санхүүжилтийг 21.0, төлбөрт үйлчилгээ болон бусад орлогыг 24.6 хувиар тус тус нэмэгдүүлэн төсөвлөсөн байна. Харин санхүүжилтийн нийт эх үүсвэрт эзлэх хувиар нь авч үзвэл улсын төсвийн санхүүжилт 79.0, ЭМД-ын сангийн санхүүжилт 18.0, төлбөрт үйлчилгээ болон бусад орлогоос санхүүжих эх үүсвэр 3.0 хувь байхаар төсөвлөжээ. Зураг 9.1.2-оос харахад төсвийн санхүүжилт сүүлийн гурван жил тогтмол нэмэгдэж, харин ЭМД-ын сан, төлбөрт үйлчилгээ болон бусад орлогоос санхүүжих эх үүсвэрийн эзлэх хувь буурсан байна.

Эрүүл мэндийн зардлын бүтэц

Эрүүл мэндийн зардлын бүтцийг 2008 оны байдлаар авч үзэхэд 74.4 хувь буюу 158,9 тэрбум төгрөгийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд, төвлөрсөн арга хэмжээнд 3.6 хувь буюу 7,7 тэрбум, хөрөнгө оруулалтад 7.8 хувь буюу 16,7 тэрбум, бусад үйл ажиллагаанд 14.1 хувь буюу 30,2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөжээ.



Эх сурвалж: Санхүү, хөрөнгө оруулалтын газар, ЭМЯ, 2008 он

Нийт хөрөнгө оруулалтын 35.3 хувь буюу 5,9 тэрбум төгрөгийг шинээр барих барилга, 30.0 хувь буюу 5 тэрбум төгрөгийг их засварт, 23.3 хувь буюу 3,9 тэрбум төгрөгийг авто машин, тоног төхөөрөмж худалдан авахад, 11.4 хувь буюу 1,9 тэрбум төгрөгийг шилжих барилгад зарцуулахаар төсөвлөсөн байна.

2008 онд хөрөнгө оруулалтанд 16,7 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2007 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 53.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 9.1.1. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт	2005 он		2006 он		2007 он		2008 он	
	Тоо	Сая.төг	Тоо	Сая.төг	Тоо	Сая.төг	Тоо	Сая.төг
Шилжих барилга	4	1 408,8	8	2 350,0	11	2 746,6	15	1 907,0
Шинээр барьсан барилга	7	390,0	7	560,0	29	3 856,9	38	5 884,0
Их засвар	32	1 088,1	35	750,0	97	1 756,5	81	5 001,9
Авто машин, тоног төхөөрөмжийн шинэчлэл	-	545,6	-	2 800,0	-	2 486,1	-	3 881,0
Нийт хөрөнгө оруулалт		3 432,5		6 460,0		10 846,1		16 673,9


Эх сурвалж: Санхүү, хөрөнгө оруулалтын газар, ЭМЯ, 2008 он

Хүснэгтээс харахад эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт сүүлийн 3 жилд 50-70 орчим хувиар нэмэгджээ.

Эрүүл мэндийн зардал, тусламж үйлчилгээний шатлалаар

2008 онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд 158,9 тэрбум төгрөг төсөвлөснөөс анхдагч шатлалын тусламж үйлчилгээнд 51,1, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээнд 62,4, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээнд 45,4 тэрбум төгрөгийг тус тус зарцуулахаар төсөвлөжээ.

Зураг 9.1.4. Эрүүл мэндийн зардал, тусламж үйлчилгээний шатлалаар, (тэрбум.төг)



Эх сурвалж: Санхүү, хөрөнгө оруулалтын газар, ЭМЯ, 2008 он

(Зураг 9.1.4)-өөс харахад санхүүжилтийн хэмжээ шатлал бүрд жил бүр нэмэгдэж байгаа ба 2008 оны төсвийг 2007 оны гүйцэтгэлтэй харьцуулахад анхдагч шатлалын тусламж үйлчилгээний зардлыг 47.3 хувь, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээний зардлыг 23.2 хувь, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний зардлыг 41.9 хувиар тус тус нэмэгдүүлэн төсөвлөсөн байна.

Анхдагч, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээний зардал гуравдагч шатлалын тусламж үйлчилгээний зардлаас өндөр болж ирж байгаа нь НЭМ, суурь тусламж үйлчилгээг хүн амд жигд, хүртээмжтэй үзүүлэх Эрүүл мэндийн салбарын үндсэн зорилгод нийцэж байна.


9.2. Эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн томоохон эх үүсвэр болох Эрүүл мэндийн даатгалын орлого, зарлагын талаарх мэдээллийг 2008 оны гүйцэтгэлээр толилуулж байна.

ЭМД-ын сангийн орлого, зарлага

Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн тогтоолоор 2008 онд ЭМД-ын сангийн шимтгэлийн орлогыг 67,4 тэрбум төгрөг, ЭМД-ын сангийн даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний зардлыг 51,3 тэрбум төгрөгөөр баталсан ба даатгалын шимтгэлийн орлогод 62,6 тэрбум төгрөг төвлөрүүлж, 50,8 тэрбум төгрөгийг даатгуулагчид үзүүлсэн тусламж үйлчилгээнд, 2,3 тэрбум төгрөгийг ЭМД-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, бусад зардалд зарцуулсан байна.

Зураг 9.2.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хяналт, санхүүжилтийн газар, УНДЕГ, 2008

(Зураг 9.2.1)-ээс харахад ЭМД-ын сангийн орлого, зарлага жил бүр өсөн нэмэгдэж байна. ЭМД-ын сангийн орлого 2008 онд 62,6 тэрбум буюу 2007 оноос 12,4 тэрбум төгрөгөөр, зарлага нь 53,2 тэрбум буюу өмнөх оныхоос 25,7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. ЭМД-ын сангийн зарлага урьд онуудад харьцангуй тогтвортой нэмэгдэж байсан ба 2008 онд урьд оныхтой харьцуулахад 1,9 дахин нэмэгдсэн нь 2008 онд ЭМД-ын сангаас тусламж үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо өмнөх оныхоос 22.8%, зардлын хэмжээ 84.7%-иар тус тус өссөнтэй холбоотой байна.

ЭМД-ын сангаас даатгуулагчийн тусламж үйлчилгээнд олгосон зардлыг өмнөх оныхтой харьцуулан харвал:


№	Тусламж үйлчилгээний төрөл	2007 он		2008 он	
		Мян.хүн	Тэрбум.төг	Мян.хүн	Тэрбум.төг
1	Хэвтүүлэн эмчлүүлсэн	238.8	20.4	378.9	39.0
2	Амбулаториор эмчлүүлсэн	669.4	3.5	837.7	7.2
3	Хувийн эмнэлгээр эмчлүүлсэн	65.0	2.5	64.1	2.5
4	Рашаан сувиллаар үйлчилүүлсэн	27.7	0.6	31.2	1.2
5	Хөнгөлөлттэй эмийн зардал	316.1	0.6	305.9	0.9
	Бүгд	1317.0	27.5	1617.8	50.8

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хяналт, санхүүжилтийн газар, УНДЕГ, 2008 он

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт, тусламж үйлчилгээний төрлөөр

2008 онд даатгуулагчид үзүүлсэн тусламж үйлчилгээний зардал болох 50,8 тэрбум төгрөгийг тусламж үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл 81.7 хувь буюу 41,5 тэрбум төгрөгийг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд, 14.3 хувь буюу 7,2 тэрбум төгрөгийг амбулаторийн тусламж үйлчилгээнд, 2.3 хувь буюу 1,2 тэрбум төгрөгийг рашаан сувилалд, 1.7 хувь буюу 0,9 тэрбум төгрөгийг хөнгөлөлттэй олгох эмийн зардалд зарцуулсан байна.

Зураг 9.2.2. ЭМД-ын сангийн зарцуулалт, тусламж үйлчилгээний төрлөөр



Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хяналт, санхүүжилтийн газар, УНДЕГ, 2008 он


2008 оны гүйцэтгэлийг 2007 онтой харьцуулахад хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний зардал 1,8; амбулаторийн тусламж үйлчилгээний зардал 3,4; рашаан сувиллын зардал 2,1; хөнгөлөлттэй олгох эмийн зардал 1,6 дахин тус тус өссөн байна.

Даатгалын хамралтын улсын дундаж 84.4 хувь байгаа нь урьд оныхоос 6.1 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс орон нутгийн даатгалын хамралт 2007 онд 74.2 хувь байсан бол 2008 онд 81.7 хувь, нийслэлийн даатгалын хамралт 2007 онд 84.5 хувь байсан бол 2008 онд 88.4 хувь болж тус тус өссөн байна.

ЭМД-ын сангийн зарцуулалт, өмчийн хэлбэрээр

ЭМД-ын сангийн даатгуулагчид үзүүлсэн тусламж үйлчилгээний зардлыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 86.5 хувь буюу 44 тэрбум төгрөгийг улсын салбарт, 13.5 хувь буюу 6,9 тэрбум төгрөгийг хувийн салбарт тус тус зарцуулсан байна.
